



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2021.01.07 №01 (10730)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

2020 ОН БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БОДЛОГО, ЗОРИЛТОО ШИНЭЧЛЭН ТОДОРХОЙЛСОН ЖИЛ БАЙЛАА

Зэвсэгт хүчний Жанжин штабын тайлангийн хуралд Батлан хамгаалахын сайдын хэлсэн үгийг бүрэн эхээр нь хүргэж байна.

Эрхэм генерал, офицерууд Та бүхэнтэй он солигдох мөчид дахин уулзаж, ЗХЖШ-ын 2020 оны үйл ажиллагааны тайлангийн хуралд оролцож байгаадаа баяртай байна.

Тайлангийн хуралд тавигдаж байгаа илтгэл, дүнгээс харахад 2020 он Зэвсэгт хүчний хувьд нэлээдгүй ажлыг амжуулсан, амжилт бүтээл дүүрэн жил байсныг илтгэж байна. Улс оронд үүссэн нөхцөл байдлын улмаас төлөвлөгөөт зарим арга хэмжээ тасалдсан хэдий ч Монгол Улсын Зэвсэгт хүчин 2020 онд мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлж, бэхжүүлэхэд ахиц гаргасан,

"Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж дүгнэсэн, цаашдын үйл ажиллагааны зорилго, зорилтоо тодорхойлсон, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Зэвсэгт хүчний удирдлагын байгууллагын тогтолцооны шинэчлэлийн эхлэлийг тавьсан, төрлийн цэргийг шинээр байгуулсан, стратегийн дэлгэн байгуулалт, дайчилгаатай холбоотой стратегийн төлөвлөлтийн томоохон баримт бичгүүдээ батлуулсан, улс орны томоохон бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчний алба хаагчдаа оролцуулсан, алба хаагчдынхаа ажиллаж, амьдрах орчин нөхцөл, нийгмийн хамгаалалд анхаарсан онцлог жил боллоо гэж үзэж байна.

Би Та бүхэнд батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хэмжээнд 2020 онд хийж хэрэгжүүлсэн зарим онцлог ажлаас товч дурдах нь зүйтэй байх гэж бодож байна.

УИХ-ын 2020 оны ээлжит хаврын чуулганаар Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Монгол Улсын Зэвсэгт хүчин түүхэн хөгжлийнхөө явцад урьд байгаагүйгээр өргөжин хөгжих эрх зүйн зохицуулалттай болсон. Ингэснээр Зэвсэгт хүчин нь Хуурай замын цэрэг, Агаарын цэрэг, Тусгай хүчний цэрэг, Кибер аюулгүй байдлын цэрэг болон Барилга-инженерийн цэргээс бүрдэхээр хуульчлагдсаныг та бүхэн мэдэж байгаа.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар Зэвсэгт хүчинд "Тусгай хүчний цэргийн командлал", "Кибер аюулгүй байдлын цэргийн командлал", "Барилга-инженерийн цэргийн удирдах газар" байгуулах шийдвэрийг гаргаж, Батлан хамгаалахын сайдын тушаалаар баталгаажуулснаар шинэ төрлийн цэргийн

удирдлагын байгууллагууд бие даан үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс бүрдсэн. Шинэ төрлийн цэргийн командлалуудыг бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах, үйл ажиллагааг нь эхлүүлэх бэлтгэл ажил хангагдаад байгаа талаар ЗХЖШ-ын дарга надад илтгэсэн.

Өнөөдрийн байдлаар УИХ-ын чуулганаар Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг хэлэлцүүлж байна. Энэхүү хуулиар "Зэвсэгт хүчний хөгжлийн сан"-г Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тусгай сангийн төрөлд хамааруулж, бүрдүүлэлт, зарцуулалтын онцлогтой холбогдсон харилцааг Зэвсэгт хүчний тухай хуулиар, нийтлэг харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулах эрх зүйн зохицуулалтыг хийж байгаа.

(Үргэлжлэл нь II нүүрт)

С.Дашзэвэг: ҮҮРГЭЭ АМЖИЛТАЙ ГҮЙЦЭТГЭЭРЭЙ, ЭХ ОРОН ЧИНЬ ХҮЛЭЭЖ БАЙГАА ШҮҮ



Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдаж буй "Шийдвэртэй дэмжлэг" энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн хамгаалалтын ротын XII ээлжийн бие бүрэлдэхүүнийг үдэн гаргах ёслолын арга хэмжээ Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн жагсаалын талбайд боллоо.

Тус арга хэмжээнд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг оролцон, XII ээлжийн цэргийн багийн захирагч, дэд хурандаа М.Түвшинжаргалд Монгол Улсын Төрийн далбааг гардуулсны зэрэгцээ аян замын ерөөлийг бэлгэдэж хадаг, мөнгөн аягатай идээг өргөн барьлаа.

Энэ үеэр бригадын генерал С.Дашзэвэг цэргийн багийн бүрэлдэхүүнд хандаж хэлсэн үгэндээ, "Тэднийг сахилга баттай, гар нийлэмжтэй ажиллаж Монгол Улсын Төр засаг, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг мэргэжлийн өндөр түвшинд биелүүлэхийг захиж, дэлхий дахиныг түгшээж буй цар тахлын үед үүрэг гүйцэтгэж байгаагаа үргэлж сан ариутгал халдваргүйжүүлэлтийн дэглэмийг чанд сахин ажиллах ёстой" хэмээн онцлов. Үүний дараа цэргийн багийн захирагч, дэд хурандаа М.Түвшинжаргал "Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад цэрэг, улс төрийн байдал тогтворгүй, дэлхий нийтийг хамарсан цар тахлын болзошгүй аюул оршин буй хэдий ч бид монгол цэргийн мэргэжлийн ур чадвар, сахилга бат, тэсвэр тэвчээр, дасан зохицох чадвараараа Төр засаг, цэргийн дээд удирдлагаас үзүүлсэн итгэлийг алдалгүй хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлнэ гэдэгт итгэлтэй байна. Монгол морьтон цэргийн удам, баатарлаг залуусын маань цог, хийморь нь мөнхөд бадарч, монгол цэргийн өлмий бат оршид болтугай" хэмээн ерөөгөөд тус ёслолын арга хэмжээнд хүрэлцэн ирсэн зочдоод баярласан сэтгэгдлээ илэрхийллээ.

ОРОН СУУЦНЫ БАТЛАМЖИЙГ ГАРДУУЛАВ

Монгол Улс Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоос сэргээн мандуулсаны 109 жилийн ойн өдрийг тохиолдуулж Батлан хамгаалах салбарын зарим алба хаагчид, тэтгэвэр, чөлөөнд байгаа ахмад дайчдад орон сууцны батламж гардууллаа. Тодруулбал, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга асан, бэлтгэл дэслэгч генерал Ц.Бямбажав, ҮБХИС-ийн багш асан, бэлтгэл хурандаа Г.Мягмаржав, А.Гэлэгжамц, Зэвсэгт хүчний Жанжин штабын Сургалтын хэлтсийн Биеийн тамир, спортын тасгийн дарга, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэ, "Алдар" спорт хорооны дасгалжуулагч, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, ахлагч Б.Хосбаяр, "Алдар" спорт хорооны тамирчин, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин, хошууч О.Гүндэгмаа, "Алдар" спорт хорооны тамирчин, Монгол Улсын гавьяат тамирчин Г.Мандахнаран, "Алдар" спорт хорооны тамирчин, Монгол Улсын гавьяат тамирчин, ахлах дэслэгч Д.Цэрэнханд, "Алдар" спорт хорооны тамирчин Б.Одончимэг, Зэвсэгт хүчний 026 дугаар ангийн жолооч асан, Монгол Улсын гавьяат тэвэрчин, чөлөөнд байгаа сургагч ахлагч Б.Хандаа зэрэг эрхэлсэн ажил, мэргэжилдээ амжилт гарган, төрийн өндөр гавьяа, шагнал хүртсэн 21 хүнд Батлан хамгаалахын сайдын тушаалаар байгууллагын мэдлийн орон сууцыг нэн хөнгөлөлттэй үнээр хувьчлах боломжийг олгож буй юм.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Миний бие Батлан хамгаалахын сайдаар томилогдсоноос хойш салбарынхаа генерал, офицер, ахлагч, ажилтан, албан хаагчид, ахмад дайчдынхаа нийгмийн хамгааллыг дээшлүүлэх, ажиллаж амьдрах ая тухтай орчин, нөхцөлийг бүрдүүлэх талаар багагүй ажлуудыг төлөвлөн, хэрэгжүүлж эхлээд байна. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын түвшинд шийдвэрлэгдсэн "Орон сууц хувьчлах тухай" 56 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж байгууллагын мэдлийн 592 орон сууцыг оршин суугчдад нь үнэгүй болон нэн хөнгөлөлттэй үнээр болон хувьчлах асуудлыг шийдлээ. Айлчлан ирж буй 2021 оны босгон дээр та бүхэндээ одоогийн амьдарч буй байгууллагын мэдлийн орон сууцыг тань тусгайлан нэн хөнгөлөлттэй үнээр эзэмшүүлэх шийдвэр гаргаж, ийнхүү уулзаж байгаадаа миний бие туйлын баяртай байна" гээд дээрх алба хаагчдад ажлын амжилт хүслээ.

ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙГ ШАЛГАРУУЛЛАА



шилдэг арга зам" ном, "Цэргийн зэвсэглэл, техник технологи" чиглэлээр тэргүүн байрт Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн захирагч, хурандаа Д.Мөнхсайханы "БМ-14-2" бүтээл, дэд байрт Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Байлдааны зэвсэглэл, техник, инновац судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Хүрэлбаатарын "Мэргэн буудагчийн бай" бүтээлүүд шалгарчээ. Харин "35 хүртэлх насны залуу судлаач"-аар Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Аюулгүй байдлын дээд сургуулийн Электроникийн тэнхимийн ахлах багш, доктор Б.Баярмөнхийн зохиосон "Криптодайчин" мэдээлэл нууцлалын программ, "Шилдэг инновацийн бүтээл"-ээр Агаарын цэргийн командлалын Агаарын довтолгооноос хамгаалах хэлтсийн ахлах офицер, ерөнхий инженер, хурандаа Ш.Аюурзана, тус хэлтсийн электроникийн инженер, ахлах дэслэгч

Т.Тайшир, автоматжуулсан удирдлагын системийн инженер, ахмад Т.Лхагваням нарын "Phoenix-2020" Монгол Улсын агаарын орон зайн хяналтын автоматжуулсан удирдлагын систем хамтын бүтээл, "Шинэ бүтээл, оновчтой санал"-аар Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагчийн орлогч, дэд хурандаа Н.Лхагвасүрэнгийн "Байлдаан, операцыг зохион байгуулах ажлын программ" бүтээлийг тус тус шалгаруулж Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр шагналыг гардууллаа. Энэ үеэр тэрээр хэлсэн үгэндээ "Жил ирэх тусам шилдэг бүтээлд өрсөлдөөр ирүүлж буй бүтээлүүдийн чанар, чансаа, шинэлэг байдал сайжирч байгаад Батлан хамгаалахын сайдын хувьд баяртай байгаагаа илэрхийлэе. Энэ удаагийн цэргийн шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл шалгаруулалтад ирүүлсэн нийт бүтээлийн тоо өмнөх онтой харьцуулахад 10 гаруй тоогоор нэмэгдсэн байна. Үүнээс Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн штабын бэлтгэлжилтийг дээшлүүлэх, салбарын галын боломжийг нэмэгдүүлэх, салаа, тасгийн сургалт бэлтгэлд ашиглагдах боломжтой цөөнгүй бүтээл ирүүлсэн нь оюуны бүтээлийн практик ач холбогдлыг нэмэгдүүлсэн сайшаалтай үйл явдал болж байна. Түүнчлэн гадаадын их, дээд сургуулиудад мэргэжил эзэмшсэн залуу инженер офицерууд маань Зэвсэгт хүчинд ашиглагдаж болохуйц хөнгөн хуягласан байлдааны машины эхний загвар болон нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн шинэ загварыг бүтээж, зэрэглэл, цэргийн техникийг дотооддоо үйлдвэрлэх, турших үндэс суурийг тавьсан нь өнгөрч буй 2020 оны онцлох бүтээлч ажил болсныг энд дурдах нь зүйтэй. Ийм бүтээлч сэтгэлгээ, бодит үр дүнг бодлогын түвшинд дэмжиж, цаашид хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх болно" гэв.

2020 ОН БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БОДЛОГО, ЗОРИЛТОО ШИНЭЧЛЭН ТОДОРХОЙЛСОН ЖИЛ БАЙЛАА

(Түрүүч нь I нүүрт)

Энэ хуульд нэмэлт оруулснаар Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулснаар энэхүү бүтээн байгуулалтад гар бие оролцож байгаа цэргийн алба хаагч залуусын цалин, орлого нэмэгдэхийн зэрэгцээ Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлого нэмэгдэх шинэ зүүсвэр бий болж, тодорхой хөрөнгө төвлөрүүлж, Зэвсэгт хүчний өмнө тулгамдаад байгаа зэвсэглэл, техникийн шинэчлэлийг хийх, бэлэн байдал, сургалт бэлтгэлийн түвшнийг дээшлүүлэх, бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэх юм.

Мөн долоо хоногийн өмнө УИХ-аар “Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг батлууллаа.

Энэхүү хэлэлцээрийг батлуулснаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлыг хангах, гуравдагч хөршийн бодлогыг хэрэгжүүлэх, хоёр орны Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэх, хамтын ажиллагаа шинэ түвшинд хүрэх, бүс нутгийн хэмжээнд цэргийн итгэлцэл, харилцан ойлголцлыг бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангах, Зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

2020 он Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бодлого, зорилтоо шинэчлэн тодорхойлсон жил байлаа. Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүн, Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтийн хүрээнд шинэ Засгийн газар эмхлэн байгуулагдсан. Энэхүү Засгийн газрын 2020-2024 онд үйл ажиллагааны хөтөлбөр УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталгаажууд байна.

Тус хөтөлбөрт “Монгол Улсын Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ” гэсэн тэргүүлэх зорилтын хүрээнд 9 дэд зорилт, 48 арга хэмжээг ирэх дөрвөн жил хэрэгжүүлэхээр тусгалаа. Төрөөс дэвшүүлсэн энэхүү зорилт, арга хэмжээг Зэвсэгт хүчний удирдлага Та бүгдтэйгээ хамтран хэрэгжүүлнэ.

Саяхан Засгийн газрын хуралдаанд 2020-2024 онд батлан хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх томоохон бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдээ танилцууллаа. Энэхүү томоохон бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд Улсын агаарын хилийн хяналтын системийн чадавхыг нэмэгдүүлэх, Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын Дата төвийг байгуулах, Зэвсэгт хүчний удирдлагын төв, Зэвсэгт хүчний Жанжин штабын барилгыг шинээр барих, бага бууны сумны үйлдвэр байгуулах, Налайх аэродромын үндсэн зурвасыг сэргээн засварлах, Зэвсэгт хүчний анги, байгууллагын мэдлийн тусгай хэрэгцээний газарт албан тушаалын орон сууц барих, “Цэргийн жишиг хотхон” төслийг хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарыг туулах чадвар сайтай тусгай зориулалтын болон цэргийн тээврийн хэрэгслээр хангах зэрэг ихээхэн хөрөнгө, хүч шаардсан төсөл, арга хэмжээ багтаж байгаа юм.

“Зэвсэгт хүчний

байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулж, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, ойрын хугацаанд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна. Удахгүй хөтөлбөр батлагдаж ирэх дөрвөн жилд мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлж, бэхжүүлэх дунд хугацааны зорилго, зорилт, хүрэх үр дүн тодорхой болох юм.

Цаашид “Монгол Улсын хууль, тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Тагнуулын байгууллагын тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай, Дайны байдлын тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусган баталгаажуулаад байгааг энд дуулгая.

2020 онд ЗХЖШ Зэвсэгт хүчний стратегийн удирдлага, төлөвлөлтийн баримт бичгүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч болон Батлан хамгаалахын сайдаар батлуулсан нь 2009 оноос хойш хүлээгдэж байсан энэхүү стратегийн төлөвлөлтийг зориглон боловсруулж, шийдвэрлүүлсэн чухал арга хэмжээ болсонд Сайд миний бие үүнд талархалтай ханддаг.

Би Батлан хамгаалахын сайдын ажлыг хүлээж аваад салбарынхаа гадаад харилцаа, хамтын ажиллагааг Зэвсэгт хүчний хөгжилд бодитой өөрчлөлт, шинэчлэл хийх тийм л бодлогоор өргөжүүлэн хөгжүүлэх зорилт тавиад ажиллаж байна.

Монгол Улсад суугаа Элчин сайд нарыг хүлээн авч уулзаж, тухайн улс бүртэй хамтын ажиллагааг хэрхэн өргөжүүлэх талаар санал солилцож, Засгийн газрын болон Батлан хамгаалахын сайдын бодлого, зорилтын хүрээнд хамтран ажиллах чиглэлүүдээ тодорхойллоо. Үүнийг хэрэгжүүлэхэд Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яамдын Батлан хамгаалахын атташе чухал үүрэгтэй. Энэ ч утгаараа ОХУ, БНХАУ, АНУ, БНТУ-д суух Батлан хамгаалахын атташе, НҮБ-ын дэргэдэх байнгын төлөөлөгчийн газрын Цэргийн зөвлөхийг тус тус томилж, үүрэг ажилд нь оруулаад байна.

2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн олон улсын болон хамтарсан сургууль, дадлагууд халдварт цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан ихэнх нь хэрэгжээгүйг Та бүхэн мэдэж байгаа. Гэсэн хэдий ч АНУ-ын тусгай хүчинтэй хамтарсан “Баланс мэжик-2020” тусгай хүчний хээрийн сургалт, дадлага, ХБНГУ-тай хамтарсан “Уулын явган цэргийн сургалт”-ыг эх орондоо амжилттай зохион байгуулж, ОХУ-тай хамтарсан “Сэлэнгэ-2020” тактикийн хээрийн сургуулийг 2 улсын нутаг дэвсгэрт нэгэн зэрэг явуулж, тус сургуулийн команд-штабын сургуульд Монгол Улсын Зэвсэгт хүчний төлөөллийг оролцууллаа.

Бид дэлхийг нөмөрсөн цар тахлын энэ хүнд цагт Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдаж буй “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд АНУ-тай хамтран үүрэг гүйцэтгэсэн “Цэргийн хамгаалалтын рот”-ын 10 дугаар ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг 2020 оны 7 дугаар сард анх удаа үндэсний агаарын тээврийн онгоцоор татан авлаа. Тус багийн 11 дүгээр ээлжийн бүрэлдэхүүнээ ч энэ байдлаар эх орондоо авч

ирэхээр ажиллаж байна.

Афганистан Улсад үүрэг гүйцэтгэж байгаа дайчид маань коронавирусийн халдвар авсан сураг дуулаад Батлан хамгаалахын сайд би ихэд санаа зовж байлаа. Харин манай цэргийн багийн удирдлага, бие бүрэлдэхүүн сэтгэл зүйн өндөр чадвар, залуу хүний эрүүл, чанга бие бялдрын хүчээр энэхүү өвчнийг даван гарч чадлаа.

Дэлхийн халуун цэгүүдэд үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаа цэрэг, дайчид та бүхнээрээ үргэлж бахархаж явдгаа илэрхийлье.

Салбарынхаа шинжлэх ухаан, технологи, инновац, судалгаа, туршилтын ажлыг хөгжүүлэхэд анхаарах цаг ирсэн гэж бодож байгаа. “Алсын харсаа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигт дэвшүүлсэн “Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэн, технологийн дэвшлийг нэвтрүүлж, Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Батлан хамгаалах яам, Шинжлэх ухааны академи хооронд хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.

Санамж бичгийн хүрээнд Батлан хамгаалах яам, Шинжлэх ухааны академи, харьяа эрдэм шинжилгээний байгууллахын материаллаг бааз, эрдэмтэн, судлаачдын оюуны чадавхад түшиглэн улс орны хөгжилд бодитой хувь нэмэр оруулахуйц аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашигт нийцсэн салбарын болон салбар дундын судалгаа, хөгжүүлэлт, туршилтын төслүүд боловсруулан хэрэгжүүлж, өргөн хүрээнд хамтран ажиллах юм.

Энэ онд Зэвсэгт хүчний Жанжин штабаас цэргийн зориулалттай хөнгөн хуягласан байлдааны машины эхний загвар болон нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн шинэ загварыг бүтээсэн нь дотооддоо цэргийн зориулалттай техник үйлдвэрлэх үндэс суурийг тавьсан чухал ажил болсныг Сайд би энд онцлон дурдмаар байна. Цаашид энэ эрчээрээ үргэлжүүлэн ажиллавал цэргийн зориулалттай зэвсэг, техник хэрэгслийг дотооддоо олноор үйлдвэрлэх нөхцөл бүрдэнэ гэдэгт итгэж байна. Ийм Зэвсэгт хүчинд наалдацтай, хөгжлийн бодлогод нийцсэн, инновацад суурилсан, төсөв хөрөнгө хэмнэсэн бүтээлч ажлуудыг Батлан хамгаалахын сайд дэмжиж ажиллана.

Мөн Зэвсэгт хүчний Жанжин штаб, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын орон тоог шинэчилж, шилжүүлсэн, ангиудын штабын бэлэн байдлын үзлэг зохион байгуулсан, нэгтгэл, анги, салбарын байдлааны болон сургууль-байдлааны техникт улирлын болон нэгдсэн үйлчилгээ, сэргээн сайжруулалт хийсэн нь маш үр дүнтэй арга хэмжээ болсон байна. Ялангуяа бэлэн байдлын бодит түвшинг дээшлүүлсэн сайн ажил болсныг онцлон тэмдэглэж байна.

2020 онд бүтээн байгуулалтын жил байлаа. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн төрөөс даалгасан улсыг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтад маш сайн ажиллаж байгаа. Энэ онд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км шинэ төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай танилцаж явахад ийм стратегийн томоохон бүтээн байгуулалтын ажлыг мэргэжлийн чадварлаг бие бүрэлдэхүүнтэй, орчин үеийн өндөр хүчин чадал бүхий техник, тоног, төхөөрөмжөөр хангагдсан, зохион байгуулалттай, манай барилга-инженерийн цэрэг л богино хугацаанд, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэж чадах юм байна гэж бодогдож байсан.

Бүтээн байгуулалтын ажилд оролцсон барилга-инженерийн цэргийн ангийн бие бүрэлдэхүүндээ Зэвсэгт хүчний нэрийг өндөрт өргөж ажилласан явдалд баярлаж байгаагаа илэрхийлье.

Энэ онд алба хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн жил байлаа. Засгийн газрын шийдвэрээр 591 офицер, ахлагч, ахмад дайчид, ажилтан, алба хаагчид амьдарч байгаа албан тушаалын байраа хөнгөлөлттэй үнээр /562/ болон үнэгүй /29/ хувьчилж аваад байна.

Эрхэм генерал, офицерууд аа!

Та бүхэнд Батлан хамгаалах талаар 2020 онд хийж хэрэгжүүлсэн зарим онцлог ажлаас товчхон танилцууллаа.

Одоо Батлан хамгаалахын сайдын хувьд Та бүхэнд ирж буй 2021 онд ажил, албандаа анхаарч ажиллах зарим нэг зөвлөмж, үүрэг, чиглэлийг өгье.

➤ Зэвсэгт хүчинд шинээр байгуулагдсан төрлийн цэргийг бэхжүүлэх, дүрмийг батлан, командлал бие дааж үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, эхнээс ул суурьтай үндэс суурийг зөв тавих нь зүйтэй.

➤ “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бодитойгоор, хэрэгжихүйц, үр дүнд суурилсан байдлаар боловсруулж 2021 оны эхний улиралд багтаан надаар батлуулах хэрэгтэй.

➤ “Жишиг цэргийн хотхон” төслийг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлээс хэрэгжүүлж эхэлнэ. ЗХЖШ, Хуурай замын цэргийн командлал энэ ажлыг хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллаарай.

➤ Зэвсэгт хүчний алба хаагчдын ёс зүй, шударга байдал, сахилга хариуцлага, ажил албандаа хандах хандлагын талаар шат шатандаа онцгой анхаарч ажиллах хэрэгтэй.

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд мөрдөгдөж буй хууль, дүрэм, ёс зүйн шаардлагуудыг тууштай, ягштал мөрдөж ажиллах нь салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг дээшлүүлээд зогсохгүй, алба хаагчдын эрхэлсэн ажилдаа хандах хандлагыг өөрчлөхөд нэн чухал ач холбогдолтой.

Засгийн газрын зүгээс ч төрийн албаны шинэтгэл, төрийн алба хаагчийн ажлын хариуцлагыг дээшлүүлэх, сахилга, дэг журмыг бэхжүүлэхийг төрийн байгууллагуудын тэргүүн зэргийн зорилт болгон тавьж, шат дараалсан олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа.

Ерөнхий сайдын баримталж байгаа шударга байх, ёс зүйтэй байх, эрхэлсэн ажилдаа эзэн байх, хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлж ажиллахыг энд дахин онцолж, сануулж байна. Энэ чиглэлээр Батлан хамгаалах салбар манлайлагч, үлгэр жишээ салбар байх ёстой.

➤ Цэргийн алба, цэргийн хөдөлмөрийн болон хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой осол, зөрчил буурахгүй, улмаар цэргийн алба хаагч эрүүл мэндээрээ хохирох, амь насаа алдах тохиолдол гарсаар байна.

Энэ талаар БХЯ, ЗХЖШ, Төрийн цэргийн командлалуудаас нэгтгэл, анги, байгууллагуудад өгсөн үүрэг, даалгавар, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж чамлахааргүй олон байгаа ч, гагцхүү тэдгээрийг ажил хэрэг болгон үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, хэвшүүлэх бүх шатны захирагч, дарга, албан тушаалтнуудын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих,

дотоодын хяналт шалгалтын чанар, үр нөлөөг эрс сайжруулах, уг асуудалд цэргийн алба хаагч бүр ухамсартай хандахад онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна.

Бүх үйл ажиллагаа хууль, дүрмийн хүрээнд явагдах учиртай. Осол, зөрчил гаргасан хэн ч бай хариуцлага хүлээх учиртайг дахин сануулъя. Шат шатандаа анхаарах хэрэгтэй.

➤ Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас “Ковид-19” цар тахлын үед улс орны эдийн засгийг дэмжих, төсвийн алдагдлыг бууруулах, гамшгийн өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэргүүдэд шилжсэн үед төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу, хэмнэлттэй зарцуулах, батлагдсан төсвийнхөө хүрээнд өмнөө тавигдсан зорилгоо биелүүлэх, бодлого хэрэгжүүлж байгаагай уялдуулж, бүх шатанд төсвийн сахилга батыг чанд сахиж ажиллах үүрэг, хариуцлага та бидэнд зүй ёсоор тавигдаж байгаа.

Үүсээд байгаа нөхцөл байдлаас шалтгаалан ирэх онд улсын хэмжээнд төсөв, санхүүгийн хүндрэл үүсэх, эдийн засгийн чадавх сулрах хандлагатай байна. Иймд батлагдсан төсвийг зардлын зүйл ангилал, зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулах, төсвийн бодит хэмнэлт гаргахад анхаарч, төсвийн үргүй зардлыг таслан зогсоох, өмнөх жилүүдэд Үндэсний аудитын газраас өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг ханган ажиллах, гаргасан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр урсгал зардлыг санхүүжүүлэхийг бууруулж, сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын арга хэмжээнд түлхүү хуваарилах боломжийг хангах, барилга-инженерийн ангиудыг улс орны бүртээн байгуулалтын ажилд оролцуулснаас олсон орлогыг Зэвсэгт хүчний хөгжлийн санд бүрэн төвлөрүүлэхэд анхаарч ажиллахыг үүрэг болгож байна.

➤ Ирэх онд Батлан хамгаалах яамны 110, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн 100, Цэргийн төв эмнэлгийн 100 гээд олон ой тохионо. Мэдээж ойн жилийг 2021 оны үйл ажиллагаатайгаа уялдуулж ажиллах хэдий ч төсвийн хүрэлцээ, нөөц хязгаарлагдмал үед олон нийтийн дэмжлэг, ард түмнийхээ оролцоотойгоор ойгоо нийтэд хүртээмжтэй, өргөн дэлгэр тэмдэглэнэ гэж бодож байна. Энэ баяр бидний бахархлын баяр болох учиртай.

Та бүхэн ч гэсэн ой угтсан бүтээлч аян өрнүүлж, олон сайхан ажлуудыг хийж хэрэгжүүлэх нь зүйтэй.

Ингээд миний өгсөн зөвлөмж, үүрэг, чиглэлд анхаарлаа хандуулсан Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүн Та бүхэнд баярлалаа.

Та бүхэнд улирч буй онд хэрэгжүүлсэн ажил үйлсээ улам бататгаж, 2021 ондоо ихийг бүтээж, их ойн жилээ амжилт бүтээлээр дүүрэн угтаж, эх орноо Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнээ хөгжүүлэх их үйлсдээ улам их амжилт гаргахыг хүсэн өрөөе.

Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүндээ ирж буй шинэ жилийн баярын мөндчилгээг Батлан хамгаалахын сайдын зүгээс болон сайдын зөвлөлийн гишүүдийн нэрийн өмнөөс өргөн дэвшүүлж, аз жаргал, эрүүл энх, хамгийн сайн сайхныг хүсье.

Монгол цэргийн сүлд, хийморь үеийн үед мандан бадраг.

БАЯРЛАЛАА ЭМЧ НАРТАА

Цэргийн төв эмнэлгийн дарга-Ерөнхий эмч, хурандаа С.БАТБОЛДОЙ шинэ оны босгон дээр холбогдож, их ажлынх нь хажуугаар цөөн хором утсаар ярилцлаа.



хурандаа Ц.Анхбаяр нар хамтран хандивын аян өрнүүлж, БХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар, нийслэл болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын хамт олноос цугларсан 4.650.000 төгрөгийн нэг удаагийн хамгаалалтын хувцас, амны хаалтыг хүлээн аваад байна. Түүнчлэн Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн захирал, бригадын генерал П.Жаргалан захиралтай хамт олноос 10 ажилтны ар гэрт дэмжлэг үзүүлж тус сургуулийн Аюулгүй байдлын их сургуульд суралцаж буй эмнэлгийн архивч О.Оюунсүрэнгийн хүүхдийн нэг жилийн сургалтын төлбөрийн 50 хувийг хөнгөлсөн эрхийн бичгийг тус тус олгосонд манай хамт олон маш их талархаж байгаагаа илэрхийлэе.

Эрхэм хурандаагийн амрыг эрье. Танд болон танай хамт олонд шинэ оны мэнд хүргэе.

-Баярлалаа. "Соёмбо" сонинхоо уншигчдад шинэ оны мэнд дэвшүүлэе.

Хамт олноо болон мянга мянган уншигчдынхаа өмнөөс Цэргийн төв эмнэлгийн эмч, сувилагч, ажилтан албан хаагчдаа баярлалаа гэж хэлэх гээд ярьж байна аа.

-Баярлалаа. Ямар сайхан урам бэ. Урмын сайхан үг энэ хэцүү цаг үед эмнэлгийн ажилтан бидэнд гэлтгүй тусгаарлалт, ажиглалтад байгаа, халдвар авсан иргэдэд маань ч хүртэл эрч хүч өгөх байх.

Тэглүүлг яах вэ. Өнөөдрийн байдлаар танай эмнэлгээс хэдэн хүн улаан бүсэд ажиллаж байна вэ?

-Цэргийн төв эмнэлгээс нийт 74 эмч, сувилагч, ажилтан албан хаагч ажиллаж байна.

Та бүхнийг онцгой цаг үед амрах завдалгүй ажиллаж байгааг бид бүхэн мэдэж байгаа. Ажилтнуудын сэтгэлзүй хэр байгаа бол?

-Бид бол тангараг өргөсөн эмч хүмүүс. Хүн ардынхаа эрүүл энхийн манаанд үргэлж бэлэн байх ёстой. Үнэндээ бол ядрах эрхгүй хүмүүс гэж хэлж болох байх. Мэдээж ачаалалтай байгаа. Гэхдээ эдгээрэд гарч байгаа хүмүүсээ харахаар ядарснаа мартчихаад улам л хичээж зүтгэдэг. Дотооддоо илэрсэн нийт халдварын тохиолдлын 500 гаруйг тус эмнэлэг хүлээн авч эмчлэн сувилж байна. Сэлэнгэ, Дархан, Говьсүмбэр зэрэг аймаг,

Баянзүрх дүүргийн эмнэлэгт гарсан голомт буюу халдвар авсан иргэдийг бүгдийг нь авсан гэж бодохоор эмч, сувилагч, ажилчдын маань ачаалал ямар байгаа нь ойлгомжтой байх.

Хэдэн хүн энэ аюулт вирусээс салж эрүүл саруул болоод байна вэ?

-Одоогийн байдлаар 237 хүн эдгээрэд эмнэлгээс гарсан.

Та нар маань хэд хоног гэртээ харилгүй ажиллаж байна вэ?

-Монгол Улсын Засгийн газрын тогтоол, УОК-ын шийдвэрээр Цэргийн төв эмнэлэг 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс үйл ажиллагаагаа зогсоож гадны улс орнуудаас ирж буй иргэдийг тусгаарлаж эхэлсэн. Үүнээс хойш хоногоор биш сараар тоолохоор л хугацаанд манай эмнэлгийн ажилтан албан хаагчид гэртээ харилгүй ажиллаж байна.

Таны хувьд ...

-Өмнө нь хамгийн удаан гэвэл 2 сар гаруй эмнэлэг дээрээ байрлаж ажилласан. Сүүлийн байдлаар эмнэл зүй эрхэлсэн орлогч дарга, хурандаа Р.Баянмөнх бид хоёр 11 дүгээр сарын 13-наас хойш буюу 55 хонож ажиллаж байна.

Шинэ оныг ажил дээрээ утгжээ...

-Баярлах завгүй л шинэ онтой золголоо.

Эмч, эмнэлгийн ажилчдын эрүүл мэнд чухал. Халдвар авсан эмч нарын биеийн байдал ямар байна вэ?

-Эмчилгээгээ хийлгээд хяналтад байна. Дэлхий нийтээрээ эмч эмнэлгийн ажилтнууд халдварт

өртөж байна. Эмч нарын өвчлөл тухайн орны эрүүл мэндийн байгууллагын хөгжил, эдийн засгийн хүчин чадал, бусад хүчин зүйлсээс шалтгаалж 15-30 хувьтай байна. Манай эмнэлгийн хувьд 2.3 хувьтай. Бид эмч, эмнэлгийн ажилтнуудаа энэхүү эрсдэлээс хамгаалах чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Эрүүл мэндийн сайдын баталсан тушаалын дагуу бүх үйл ажиллагааг явуулахаас гадна нэмэлтээр техник, тоног төхөөрөмжийн хангалт, хяналтын ажиллагааг сайжруулах, камерын системийг нэмэгдүүлэх чиглэлд түлхүү анхаарч ажиллаж байна.

Цэргийн төв эмнэлэгт 2D системийг нэвтрүүлсэн. Камерын хяналтын системийн хажуугаар бие биеэ хянах механизм гэж хэлж болно. Энэ нь үр дүнгээ өгч байгаа. Ер нь халдвар авсан эмч, ажилтнуудын ар гэр, ахуй амьдралд нь Батлан хамгаалах яамнаас олон талын дэмжлэг, туслалцаа үзүүлж байгааг онцолмоор байна

Хамгаалалтын битүү хувцсыг эмч, сувилагчид өдөрт хэдэн цагаар өмсдөг вэ?

-Өдөрт 4 удаа өмсдөг. Нэг

өмсөхдөө дунджаар 1.5 цаг тайлахгүй ажилладаг. Яаралтай үед цаг нар гэлгүй өмсөөд л ажиллана шүү дээ.

Онцгой байдлын үед ажиллаж буй эмч ажилтнуудынхаа нийгмийн асуудалд хэрхэн анхаарч ажиллаж байгаа бол?

-Батлан хамгаалах яамнаас Цэргийн төв эмнэлгийн эмч, ажилтнуудаа дэмжих зорилгоор санхүүгийн болон эд материал зэрэг тал бүрийн туслалцаа, дэмжлэгийг үзүүлсээр байгаа. Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу COVID-19-ийн үед үүрэг гүйцэтгэж буй эмч, эмнэлгийн ажилтнуудад нэг сарын цалин 3 дахин нэмэгдүүлж олгосоор ирсэн. Хамгийн сүүлд гэхэд Батлан хамгаалахын сайдын санаачилгаар он солигдох мөчид ажиллаж байсан 116 эмч, сувилагч, эмнэлгийн ажилчдын ар гэрт хонины мах, чацарганын шүүс болон амны хаалтыг яамнаас томилогдсон бүрэлдэхүүн хүргэж өгч баярын мэнд хүргэсэн. Мөн Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга хурандаа С.Ганбямба, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга,

Та нартаа амжилт хүсээд дахин баярлалаа гэж хэлье ...

-Би ч бас биднийг дэмжиж тусалж урам зориг өгч буй Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд баярлалаа гэж дамжуулъя. Ялангуяа БХЯ, ЗХЖШ, "Монгол цэргийн нэгдсэн холбоо" ТББ-ын хамт олонд талархаж буйгаа дахин хэлэхийг хүсэж байна. Бид хамтдаа хичээж, дор бүрнээ хариуцлагатай байж энэ аюулт цаг үеийг даван туулах болно.

Цагаан нөмрөгт баатрууд маань цар тахлын аюул тулгарсан энэ цаг үед өгсөн үүрэг даалгаврыг хариуцлагатай биелүүлж, иргэдийнхээ эрүүл мэндийн төлөө өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж байна. Дотоодод илэрсэн халдварын тохиолдлын 70 хувийг тус эмнэлгийн хамт олон хүлээн авч, эмчлэн эдгээжээ. Үүнээс илүү сайхан мэдээ юу байх билээ. Энх цаг ирэх өдөр ойртсоор ...

Дэд хурандаа Х.ГАНЗУЛ

2002 онд өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагт хувирч хийсэн уг ярилцлагыг бүрэн эхээр нь толилуулж байна

ХМАН

Товч танилцуулга
Нэр -Х ман
Нас -28
Боловсрол -Дээд
Албан тушаал -Зэвсэгт хүчний ... дугаар ангид ротын захирагч
Цэргийн цол -Ахмад
Гэр бүл -Эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг

Танд суралцах боломж хэр байна вэ, (Элсэх сургуулийн хувьд)

- (1970-1990)-1**
-Удахгүй би МАХН-д элсэх гэж байгаа. ЗХУ-д академид суралцах өргөдөл өгөх бодолтой байна.
- (1990-2010)-2**
-Хэлний бэрхшээл байна. Уг нь боловсролоо дээшлүүлэх санаа бий. Даанч манай ангид гадаад хэлний сургалт байхгүй.
- (2010-...)-3**
-Ротын захирагчийн дамжааг өнгөрсөн жил төгссөн. 3 жилийн дараа батальон захирагчийн дамжаанд элсэх шалгалт өгнө. Тэгээд магистр хамгаалах ёстой.

Гадаад мэдээ авах боломж Танд нээлттэй юу. Элсвэл хязгаарлагдмал уу?

- "Советский воин", "Зарубежное военное обозрение" сэтгүүл захиалдаг.
- Хаалттай биш хэдий ч нээлттэй биш. Манай анги интернэттэй холбогдоогүй. Гадаад хэвлэл захиалах боломж хомс.
- Хурдыг нь гүйцэхгүй зовлон бий. Анги дээр интернэтийн тусгай танхимтай. Гэртээ мэдээллийн хоёр сүлжээнд холбогдчихдог.

Та даргынхаа тушаалыг буруу ч бай, зөв ч бай цэргийн хүний ёсоор үг дуугүй биелүүлдэг үү. Эсвэл ямар нэг тайлбарыг зоригтой хэлж чаддаг уу?

- Даргын тушаал хууль. Буруу тушаал өгөхгүйгээ манай дарга мэдэх байлгүй.
- Олон ургальч үзлийн үе биз дээ? Хуулийн хүрээнд гэж байгаад л буруу зүйлийг шууд хэлнэ.
- Гэрээгээр хүлээсэн үүргийнхээ хүрээнд л ажилладаг. Би салбараа захирагчаар юм хэлүүлэхээргүй командалдаг учир ийм явдал гардаггүй.

Та орон сууцтай юу?

- Одоохондоо ахьндаа амьдарч байна. Орон сууц хүсэж өргөдөл өгсөн. Очер хүлээж байна.
- Засгийг хараад горьдлого алга. Өөрийн гэсэн оронтой болох гээд хэдэн төгрөг хураах санаатай. Болж өгөхгүй л байна. Цалин, орлого хүрэхгүй байна шүү дээ.
- Салбарын захирагчийн албан тушаалын байранд суудаг. Цэргийн албаны дараа хувийн орон сууцанд амьдрах баталгаагаа хангаж байна.

Та хувиараа бизнес эрхэлдэг үү?

- Бизнес гэж юу юм бэ? Дамын наймаа юу? Өө, үгүй чинь.
- Өнөөгийн нөхцөлд гарцаагүй хэрэгцээ. Гэхдээ цэргийн бидэнд тийм боломж байхгүй. Хуулиар хориглочихсон. Харин үүнийгээ хариуд төр засаг нэг юм бодох байлгүй.
- Ийм шаардлага байхгүй. Би мэргэжлийн цэргийн албан хаагч учраас орлого хүрэлцээтэй. Сайн ажиллавал орлого төдий чинээ нэмэгдэнэ.

Тус сонин оны өмнөх дугааруудад "Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-тэй холбогдол бүхий цуврал нийтлэлийг уншигч Та санаж байгаа биз ээ. Энэ удаад бид эл ярилцлагаар "Цэргийн хүн"-ий алба амьдралын зарим бүрдэл хэсгийг орчлонгийн эргэх хүрдний 3 цагаар харуулахыг зорьсон юм. Ингэхдээ түүх сөхөж, өдгөөг нурун өнийн их мөрөөдлийг цааснаа буулгахаас зайлсхийж блиц хэлбэрийг сонголоо.

Ярилцлагын маань баатар бодит хүн биш бөгөөд 1970-1990, 1990-2010, 2010-... он хүртэлх 3 цагт ид насны амьдралаа Монгол Улсын төлөө зүтгэж өнгөрөөсөн, өнгөрөөж буй, өнгөрөөх жирийн л нэг офицер. Энэ офицер Та ч байж болно. "Х-ман"-ийг төлөөлж хошууч генерал Б.Шагдар хариулж байна.

Таны сарын цалингийн хэмжээ хэдэн ширхэг талхны үнэтэй тэнцэх вэ?

- Тооцож үзээгүй юм байна. Одоо бодчихъя. 240-өөд ширхэг.
- Нарийн тооцохгүй бол манай хүн хамаагүй үрчих гээд байдаг юм. Тэгээд ч сүүлийн 2 сар хэмнээд талх аваагүй.
- Заавал яагаад талх гэж?! Өөр идэх юм зөндөө л байна ш дээ.

Тэгвэл цалингаа хураавал хэдэн жилийн дараа машинтай болох вэ?

- Машин авна гэж ердөө боддоггүй.
- 70 сар буюу 6 жилийн дараа бол ч ... Гэхдээ өнөөгийн ханшаар шүү.
- Манайх 2 машинтай. Дахин авах хэрэгцээ байхгүй.

Анги, байгууллага чинь Таны ажиллах орчныг бүрдүүлж чадсан уу?

- Хангаж байна, хангаж байна. Сандал, ширээ гээд л бүх юмаар.
- Бидний сэтгэлгээний өөрчлөлтийн хурд ахуйн өөрчлөлтөөс хамаагүй түрүүлчээд байна шүү дээ. Оюуны хэрэгцээний хувьд бараг л дэвшил гаргаагүй байна.
- Энэ шаардлага хангагдаагүй тохиолдолд би гэрээ хийхгүй ш дээ.

Та хэдэн орны хэлээр ярьж чадах вэ?

- Орос хэл дунд зэрэг. Академийн шалгалт өгчих байхаа.
- Хэл сурахтай манатай. Уг нь англи хэл гадарладаг болчихвол зүгээр юм сан.
- Өнөө үед ядаж 2 хэл эзэмшихгүйгээр офицер байх боломжгүй. Орос, англи хэлтэй. Хятад хэл бие даан сурч байна.

Анги, байгууллагаас чинь бие бүрэлдэхүүнийхээ оюуны хэрэгцээнд оруулсан 3 том хөрөнгө оруулалтыг нэрлэнэ үү?

- Онолын бэлтгэл хичээл. Танхимуудыг тохижуулахад нэлээд ватум цаас олгосон. Хөрөнгө оруулалт гэдгийг сайн ойлгохгүй байна л даа.
- Телевизор. Байнгын бүрэлдэхүүн төвтэй сургалтад шилжсэн явдал.
- Цэргийн зохион байгуулалтын төгөлдөржилт, офицерын сургалтын шинэ тогтолцоо, мэдээлэл авах таатай орчин.

Таны бахархал?

- Эх орноо хамгаалах мэргэжилтэй болсон явдал.
- Бага ч гэсэн баталгаатай цалин хангамжтай байгаад сэтгэл өөг байдаг.
- Өөрийгөө хөгжүүлэх хамгийн таатай орчинд ажиллах завшааныг олон хүнтэй өрсөлдөж олж авснаараа бахархдаг.

Мэргэжлийн армийн талаарх Таны бодол ...

- Хөрөнгөтөн орны хөлсний цэргийг хэлээд байна уу? Эх орноо хамгаалах чинь иргэн бүрийн ариун үүрэг.
- Зөв бодлого шиг байгаа юм. Над мэт нь түүнд хүртэл хол байна.
- Мэргэжлийн арми нийгмийн оюуны цөм. IQ өндөртэй хүмүүсийн алба.

Тэтгэвэрт гараад Та юу хийх вэ?

- Нэг газар жижүүр манаа хийгээд талхны мөнгөний нэмэр хайна даа.
- Бодсон юм алга. Тэтгэвэрт гартал зай ч байна, лай ч байна. Яаж ийгээд зүүгдээд байна даа.
- Би цэргээс тэтгэвэрт гарахгүй. Батальон 3 жил командлаад 34 настай халагдана. Бизнесийн салбарт ажиллана.

Хэрвээ Та Батлан хамгаалахын сайд байсан бол ...

- Орон сууц барих ажлыг өргөтгөнө. Одон медаль олгох хугацааг богиносгоно. Цэргийн хуулийн байгууллагыг бэхжүүлнэ.
- Цалин, тэтгэвэр нэмнэ. Цомхотгож халахыг багасгана. Цэргийн гаргасан хэргийн төлөө даргыг нь шийтгэхээ болино.
- Өөрийгөө хөгжүүлэх чиглэлийг Зэвсэгт хүчинд тогтоож, боломжийг олгоно. Өөрийгөө хөгжүүлж чадсан бүхнийг дэмжинэ.

Асуулт маань нь үед амаргүй байсан уншигч Танд өндүү энгийн, олон өндий даавууны өөдсийг цуглуулсан мэт санагдаж ч магад. Уг асуулт, харуултыг уншиж өөрөө харуулчхаад Танд ямар нэг санаа сэдэл төрж, өнгө аяс бодогддог, бас нэгийг мэдэгдүүлж байвал боллоо. Урьд ч сайхан байж дээ. Одоо ч хэрэг алга. Эсвэл одоо ч сайхан болжээ. Дээх

Х.ЗУЛ

АВЬЯАСЛАГ ЦЭРГҮҮД

С.Мишээлт: ЭР ХҮН ЗОВОХ ТУСМАА ХАТУУЖИЖ, ЭРДЭНИЙН ЧУЛУУ ЗҮЛГЭХ ТУСМАА ГЯЛАЛЗАНА

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд хугацаат цэргийн алба хаагчдаа цэргийн эрдэмд сургахаас гадна өөрийгөө хөгжүүлэх, сэтгэн бодох чадварыг нь нэмэгдүүлэх зорилгоор уралдаан, тэмцээнүүдийг тогтмол зохион байгуулдаг уламжлалтай. Олон дунд зурах, дуулах, бүжиглэх, хөгжимдөх, хөөмийлөх, уран унших гээд олон төрлийн авьяас чадвараараа бусдаас ялгарах залуус байдаг. Энэ удаагийнхаа дугаарт содон, гайхам авьяасаараа бусдыгаа хошуучилсан хоёр байлдагчийг онцоллоо.

Санжаасүрэнгийн Мишээлт. Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн харуулын тусгай ротын нэгдүгээр салааны хоёрдугаар тасгийн захирагч, дэд түрүүч. Тэрээр 2020 оны Зэвсэгт хүчний Жанжин штабын Ажиллагааны удирдлагын газрын харьяа ангиудаас шалгарсан "Тэргүүний хугацаат цэргийн алба хаагч", Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн "Тэргүүний байлдагч"-аар тус тус шалгарсан нэгэн.

2020 оны нэгдүгээр ээлжээр Өвөрхангай аймгаас тус ангид татагдан иржээ. СУИС-ийн морин хуурын 2 дугаар курст сурч байхдаа жилийн чөлөө авч цэргийн алба хааж байгаа бөгөөд долоодугаар ангиасаа эхлэн морин хуураар хичээллэж эхэлжээ. Багын сэргэлэн цовоо, сониуч, идэвхтэй тэрээр морин хуураас гадна гадаад хэл сурах сонирхолтой бөгөөд англи хэлний академик түвшний мэдлэгтэй аж. Зуны амралт болон бусад чөлөөт цагаараа өөрийгөө хөгжүүлэх, хэл сурах, морин хуур тоглох чадвараа дээшлүүлэх үүднээс гадаадын зочид төлөөлөгчид хөтөч хийдэг байжээ. Тодруулбал цэргийн албанд ирэхээсээ өмнө "Mongolian Alpha Team Tour LLC"-д аялал жуулчлалын хөтөч,

Монголын хэл хуурын холбоонд удирдах зөвлөлийн гишүүн, хэл хуурын туслах багш, "Mongolian Nomadic Art LLC" ерөнхий менежер, хөгжимчин зэрэг ажлыг хийж байжээ. Хөдөлмөрч хүн түүнийхээ үр шимийг хүртэж байдаг гэдэгчлэн санхүүгийн хувьд ч тэр бүрэн бие даасан бөгөөд их сургуулийн төлбөр болон бусад хэрэглээний зардлаа өөрөө хариуцдаг хэмээн ам бардам хэлж байсан.

2020 оны нэгдүгээр ээлжээр цөөн тооны хугацаат цэргийн алба хаагч татах талаар мэдээлэл аваад би энэ удаад л тэнцэж, Хүндэт харуулын ангид очно хэмээн зарлан дуудах хуудсаа өвөртлөн нутгийнхаа цэрэг татлагын товчоогоор очсон түүний хүсэл биелж хүссэн зорьсон ангидаа татагдан ирсэн нь энэ.

Эхний үед шантармаар, хэцүү байсан ч тэрээр "Эр хүн зовох тусмаа хатуужиж, эрдэнийн чулуу зүлгэх тусмаа гялалзана" хэмээн өөртөө хэлж цэргийн албандаа дадаж, дасан зохицож чадсан. Тэр ч бүү хэл ирээд дөрвөн сарын дараа анхны цэргийн ёслол хүндэтгэлийн ажиллагаандаа оролцжээ. Анхны арга хэмжээ ямар

санагдсан бэ гэж асуухад тэрээр үгээр хэлэхийн аргагүй омогшил бардамналыг мэдэрсэн. Хүндэт харуулын ганган улаан хувцсаа өмсөөд, ангийнхаа хашаагаар жагсаад гарахад замын хөдөлгөөнийг түр зогсоосон байсан бөгөөд замын хажуугаар явж байгаа иргэд бичлэг хийж, зураг дараад л үнэхээр эр хүн болсондоо, цэргийн алба хааж байгаагаараа бахархсан хэмээн дурссан.

Үүнээс хойш төрийн болон цэргийн ёслол хүндэтгэлийн ажиллагаанд нийт 60 гаруй удаа оролцжээ. Үүнд нь Үндэсний их баяр наадмын нээлт хаалт, Бүх цэргийн Их хар сүлдийг цэнгүүлэх, Төрийн далбаа мандуулах, Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдыг угтан авах, Төрийн тахилгат уул тахих ёслолын ажиллагаанууд багтаж байна.

Энэхүү үндсэн үүргээсээ гадна тэрээр ангийн болон ротын мэдээлэл сурталчилгаа, соёл, хүмүүжлийн ажилд идэвхтэй оролцож, сагсан бөмбөг, ширээний теннис, гар бөмбөгийн тэмцээн, урлаг соёлын бүхий л арга хэмжээнд амжилт үзүүлж "Авьяаслаг байлдагч"-аар шалгаран, мөн "Онц сурлагатан" тэмдгээр шагнагдаж байжээ. Монгол генералын өдрийг тохиолдуулан бүх хугацаат цэргийн алба хаагчдыг төлөөлж Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын хөгжимчидтэй хамтран хүндэтгэлийн арга хэмжээнд оролцсон юм. Үүнээс гадна

Хүндэт харуулын тусгай ротын цэргийн байрны үзэмж муудаж, эд аж ахуйн эдлэгээний хугацаа дууссан учир ХХТР-ын 65 жилийн ойг тохиолдуулан иж бүрэн засвар үйлчилгээг орчин үеийн дэвшилтэт шийдлээр тохижуулах ажилд гар бие оролцсон ажээ.

Тэрээр хэлэхдээ манай ангийн удирдлагууд надад итгэл хүлээлгэн үргэлж дэмжиж морин хуураа давтах цаг гаргаж өгсөн учир дээрх арга хэмжээнүүдэд амжилттай оролцохын зэрэгцээ бусад цэргийн алба хаагчдаа морин хуур болон англи хэл зааж байгаа гэв. Үүнээс гадна бусад найзуудаасаа харилцан суралцаж солонгос, орос хэлний мэдлэгээ дээшлүүлж байгаа гэнэ.

Хүн цэргийн алба хаагаад дан ганц бие бялдраа хөгжүүлэх бус бүх талаараа хөгжөөд харих боломжтой байдгийг өөрийн биеэр мэдэрлээ. Тиймээс залуусыг цэргийн алба заавал хаа, чиний хамгийн зөв сонголт байх болно хэмээн захиж байсан юм.

Цэргийн сургалт бэлтгэлд идэвхтэй хамрагдан, дэд түрүүчийн үүргээ алдаа, зөрчил дутагдалгүй биелүүлж, салааны бие бүрэлдэхүүний хамтач, хүнлэг, нөхөрсөг харилцааг бэхжүүлэх, оюуны болон бие бялдрын хүмүүжил, сахилга батыг бэхжүүлэх талаар идэвхтэй санаачилга гарган хугацаат цэргийн алба нэр төртэй хааж байгаа Зэвсэгт хүчний эрэлхэг, дайчин цэргүүдийн нэг юм.

Түүний цаашдын төлөвлөгөөг сонирхоход алба нэр төртэй хааж дуусгаад их сургуулиа амжилттай төгсөнө. Мөн одоо сурч байгаа солонгос, орос хэлнийхээ мэдлэгийн түвшнийг дээшлүүлж, морин хуурынхаа багштай хамт гарын шавь бэлдэх хэмээн торохгүй харилж байсан.

Зэвсэгт хүчинд алба хааж байгаа олон олон хөвгүүд яг түүн шиг хүсэл мөрөөдөл дүүрэн нэгэн оноо үдэж, шинэ оноо угаж байгаа. Эх орныхоо өмнө хүлээсэн үүрэг, өргөсөн тангарагтай эр цэрэг та бүгдийн хүсэл бүхэн биелэх болтугай.



О.Болдсайхан: ОЛОН ЗУРАГ БАЙХГҮЙ ЭЭ, ОЙРОЛЦООГООР 300 ОРЧИМ Л...

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн хугацаат цэргийн алба хаагч О.БОЛДСАЙХАН. Тэрээр шинэ оны босгон дээр Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийнхэн дайчдынхаа дунд гар зураг болон шүлгийн уралдааныг зохион явуулахад зургийн төрөлд 15 хугацаат цэргийн алба хаагчаас олон төрлийн хөрөг зураг зурж тэргүүлжээ.

Өөрийгөө танилцуулахгүй юу?
-Намайг байлдагч Отгон овогтой Болдсансар гэдэг. Ам бүл долуулаа. Аав ээж, ах, хоёр эгч, дүүтэйгээ амьдардаг. Ханхонгор суманд 12 дугаар анги төгссөн. Ханхонгор сумын Ерөнхий боловсролын дунд сургууль маань мэргэжлийн сургалттай сургууль бөгөөд би тэнд таван жил уран зургийн ангид сурсан. Ерөнхий боловсролын сургуулиа төгсөөд СУИС-д монгол зургийн ангид элсэн орж, нэг жил суралцаад хувийн шалтгаанаар сургуулиа орхисон. Нутгаасаа цэргийн албанд татагдаж ирсэн.

Цэргийн алба хаах санал өөрийнх тань байв уу?
-Цэргийн албанд өөрийнхөө хүслээр ирсэн. Цэргийн алба хаагаад ирсэн нутгийн ах нар цаанаа л нэг өөр харагдаад байсан учир сэтгэл хоёрдолгүй шийдвэрээ гаргасан. Энэ сонголтыг хийсэн нь миний энэ насандаа хийсэн хамгийн зөв алхам байжээ гэж одоо бодож байгаа.

Энд ирээд олон зүйлд суралцаж байгаа биз ...
-Цэргийн алба ямар байдаг бол гэж их боддог байлаа. Гэтэл энд ирсэн эхний өдрөөсөө л суралцаж эхэлсэн. Амьдралын ухаанд илүү суралцаж байна гэж хэлж болно. Тухайлбал, тэвчээр хатуужил, авхаалж самбаа, нягт нямбай байдал гээд олон зүйлийг нэрлэж болно. Түүнчлэн цэргийн байраа цэвэрлээд, өөрийн ариун цэврийг илүү сайн сахиж, өмсөж байгаа хувцсаа цэвэр цэмцгэр өмсөж эдэлж, найз нөхөдтэйгөө зөв харьцаж сурч байна. Мөн олон найз нөхөдтэй боллоо. Эдгээр нь

миний амьдралд ихээхэн нөлөөлөх эрдмүүд юм. Цэргийн алба хаах насны, зарлан дуудах хуудас хүлээн авч байгаа залуусыгаа эргэлзэлгүй албаа хаагаарай л гэж хэлбэ.

Цэргийн албанд ирэхээсээ өмнө юу хийдэг байв?
-Өмнөговь аймагтаа ахтайгаа нийлж барилгын ажил хийдэг байсан.

Чөлөөт цагаараа юу хийж байна вэ?
-Чөлөөт цагаараа ном уншиж, бие бялдраа хөгжүүлж турник дээр дасгал хийж, хааяа кино үздэг. Соёл хүмүүжлийн зааварлагч нарынхаа төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байгаа соёл, олон нийтийн ажилд идэвхтэй оролцдог.

Шинэ оны босгон дээр ангидаа зохион байгуулагдсан зургийн уралдаанд тэргүүлсэн гэсэн?

-Багаасаа зураг зурах сонирхолтой байсан бөгөөд хоёрдугаар ангиасаа анх зураг зурж эхэлсэн. Наймдугаар ангиасаа Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Ерөнхий боловсролын сургуулийн зургийн дугуйланд орсноор зураг зурах техникт суралцаж эхэлсэн. Гэвч их сургуулиа орхисноор зураг зурахаа бүр больсон байлаа. Харин манай ангид зургийн тэмцээн зохион байгуулагдсанаар зургаа ахиж зурах болсон. Тэгээд бүр тэргүүн байр эзэлсэндээ маш их баяртай байна. Цаашид чөлөөт цагаараа зургаа үргэлжлүүлэн зурна.

Ямар төрлөөр зургаа зурдаг вэ?
-Ерөнхийдөө хөрөг зураг, бурхан зурах сонирхолтой. Хөрөг зургийн хувьд хичээл заалгаж байгаагүй ч өөрийнхөө сонирхлоор зурдаг юм. Хараад л зурмаар санагдсан,

гэнэт санаанд буусан зургаа цаасан дээр хурдан буулгах дуртай. Жишээлбэл, дэлхий дээр байхгүй сонин зүйлийг илэрхийлж гаргаж ирдэг гэх ч юм уу. Төсөөллийн зүйлийг бодит мэт цаасан дээр буулгах таатай байдаг. Өөрийн толгойд орж ирсэн зүйлээ илэрхийлээд зураад байх нь миний хувьд тайвшрал болдог.

Бурхны зураг зурахад анхаарах зүйл байдаг уу?

-СУИС-д нэг жил суралцахдаа монгол зургийн ангид суралцаж байсан. Монгол зургийн төрөлд нь бурхны зураг ордог юм. Бурхны зураг нь тухайн бурхнаа яг таг зөв зурах ёстой бөгөөд юу ч орхиж болохгүй. Мөн өнгийг хамгийн их анхаарах ёстой бөгөөд нарийхан зураас маш их байдаг. Түүнийг маш чамбай зурахад анхаарах хэрэгтэй. Нарийн ажиллагаа ихтэй хамгийн хэцүү төрөл. Ийм ч учраас өөрийгөө сорих үүднээс бурхан зурдаг.

Урын санд чинь хэчнээн зураг байдаг вэ?

-Олон зураг байхгүй ээ, ойролцоогоор 300 орчим зураг зурсан байх. Багаасаа зурж байсан хэдий ч хадгалж, тоолж байгаагүй.

Зураг зурахад анхаарвал зохих зүйлс байдаг уу?

-Зураг зурахдаа эхлээд хамгийн түрүүнд яг юу зурах гэж байгаагаа маш сайн эргэцүүлж бодох хэрэгтэй. Харж зурах, дүрсэлж зурах нь ажиллагааны хувьд өөр өөр байдаг. Харж зурах нь арай хялбар гэсэн үг. Харин дүрсэлж зурахад арай өөр. Өөрийнхөө бодсон зүйлээ цаасан дээр буулгана, бодит болгоно гэдэг чинь ур чадвар. Мөн зураг зурахад орчин маш чухал. Ямар нэгэн юмнаас мэдээлэл олж авч, түүнийгээ ургуулан бодож баяжуулж чадвал илүү баялаг, бодит зураг болдог. Миний хувьд өглөө эрт, гэгээлэг орчинд чихэвч зүүж зураг зурах дуртай. Ихэвчлэн ганцаараа байхдаа зургаа зурдаг.

Гэрийнхнээс нь зурдаг хүн бий юу?
-Манай гэрийнхэн бүгд гарын дүйтэй. Ах маань их сайхан зураг зурдаг байсан. Мөн манай ээжийн аав нутагтаа алдартай



мужаан, зураг зурдаг хүн байсан гэдэг. Тиймээс бид ээжийн талаас зураг зурах авьяасыг өвлөсөн гэж боддог юм.
Шинэ он гараад удаагүй байна. 2021 оныхоо зорилгоос сонирхуулахгүй юу?
-Нэгтгэлийнхээ нийт хамт олонд болон аав ээж, хамаатан садандаа айлчлан ирж байгаа 2021 оны мэнд хүргэе. Нэгтгэлийн хамт олонтойгоо илүү их зүйлд суралцаж, тэрхүү сурсан мэдсэн зүйлээ амьдралдаа хэрэгжүүлж эх орон, нутаг ус, ээж аавдаа хэрэгтэй иргэн хүү нь болж очно гэсэн зорилгыг өөртөө тавиад байна.
Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

Залуус

Д.Сайнбаяр: АЛИВААГ САНАСАНДАА ТУЛТАЛ ХИЙХ НЬ

"SAYAN" группийн үүсгэн байгуулагч, "Инжинаш" паблишинг"-ийн захирал Д.САЙНБАЯРЫГ урьж ярилцлаа. Тэрбээр залуучуудад олон талаар үлгэр дуурайл болдог шинэ үеийн лидерүүдийн нэг.

Юуны өмнө танд шинэ оны мэнд хүргэе ...

-Баярлалаа. Намайг ярилцлагад урьж, олон мянган цэрэг дайчидтай уулзуулж байгаа танай сонины хамт олонд болон эх орноо батлан хамгаалж, дархан хилийн манаанд зогсож буй эрэлхэг залуус, бүсгүйчүүддээ, цар тахлын энэ хэцүү үед хамгийн ачаалалтай ажиллаж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний нийт алба хаагчдад шинэ оны баярын мэнд хүргэе.

Тун завгүй хэдий ч миний урилгыг хүлээн авч манай сонины уншигчдад цаг гаргаж байгаа чин сэтгэлээсээ баярлаж байна ...

-Ажлын ачаалал их байгаа ч "Соёмбо" сонины редакцын урилгаас татгалзаж зүрхэлсэнгүй. Цэргийн сонины шинэ оны анхны дугаарт уригдах нь нэр төрийн хэрэг юм. Миний хувьд маш дурсгалтай үйл явдал гэж хүлээн авч байна.

Шинэ оныг ямар ажлуудтай угтсан бэ. Өөрөөр хэлбэл та яг одоо ямар ажил өрнүүлж байна вэ?

-Би яг одоо өөрийн ажиллуулдаг "Инжинаш

болсон. Одоо "Ард" санхүүгийн нэгдлийн "Apprentice" гэж шоу нэвтрүүлэг гарч байна. Та үзэж байгаа юу? Ер нь яагаад энэ нэвтрүүлэгт анх орсон бэ?

-2008 онд Америкаас түр хугацаагаар ирээд байхдаа тус нэвтрүүлэгт орж байлаа. Одоо бодоход "IegaTech" компанид программистаар ажилладаг 26 настай залуу байж. Есөн жил байхгүй байж байгаад ирсэн болохоор өдөр нь Монголынхоо нийгэмтэй танилцаж, найз нартайгаа хамтарч бичсэн номоо хэвлүүлэх, гадаадад суугаа монголчуудын сонгуулийн эрхийн талаар намуудын удирдлагуудтай уулзах зэрэг олон нийтийн ажилд оролцдог байлаа. Цагийн зөрүүнээс хамаарч шөнө нь Чикаго дахь оффисынхоо сервер рүү VPN-ээр нэвтэрч цаашлаад 22 мужийн сервертэй холбогдож ажлаа хийдэг байв. Эмээгийнхээ их очно. Нэг удаа "Global CEO" нэвтрүүлэгт бүртгэж байна гэсэн реклам "UBS" телевизээр гарч байлаа. Эмээ зурагт руу заагаад ч энэ нэвтрүүлэгт орвол яасан юм, одоо Монголдоо ажиллах цаг чинь болсон, өөрийгөө сорь, миний



ИРЭЭДҮЙДЭЭ МАШ ИХ ЦАГ ХЭМНЭХ ҮНДЭС БОЛДОГ

Паблишинг" ХХК-иас эрхлэн гаргасан "Сониучхан" хүүхдийн цуврал номын борлуулалт, орон нутаг, гадаад улсууд руу хийх түгээлт дээр илүү анхаарч байна. Английн "ПанМакмиллан" компаниас албан ёсны эрхийг нь аваад хавраас хойш ковидын хөл хорионы далимаар гэртээ суугаад өөрөө орчуулснаараа очнолго. Энэ номын эхний таван цуврал нь оны өмнөхөн хэвлэлтээс гарсан. Шинэ жилийн баяраар бүрэн зарагдаж дуусаад одоо хоёр дахь хэвлэлтээс гарч байна. Нэг ёсондоо сүүлийн долоон хоногийн дотор манай компанийн борлуулалт Монголын цахим худалдааны түүхэнд дээд амжилт тогтоолоо. Хамтарч ажилладаг байгууллагууд, харилцагчид бидэнд баяр хүргээд сайхан л байна.

Танайх дээд амжилт эвдсэн гэсэн үг үү?

-Тиймээ. Хамтарч ажилладаг борлуулалтын компаниудын дата тийм үзүүлэлт харуулж байна. Өдөрт хэдэн зуун багц номын захиалга иргэдээ хүлээн аваад түгээлтийн гурван компанитай гэрээ байгуулж ажиллаж байгаа. Ковидын үеэр замын түгжрэл бага байгаа нь манайд давуу тал болж байна. Гэхдээ он гараад QR код шинээр авах гэх зэрэг түгээлтийг удаашруулах хүчин зүйлстэй тулгарч байгаа ч бид 24 цагийн дотор хүргэлтээ хийсээр байна. Хөдөө орон нутагт ч захиалга ихтэй. Манай фэйсбүүк хуудаснаас хүмүүс захиалгаа хийж байна. Би танай сонины уншигч, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд борлуулж буй бүх номынхоо үнийг 15 хувиар хямдрүүлэн шинэ жилийн бэлэг барья. Манай компанийн "Инжинаш бархан" гэж фэйсбүүк хуудсаар зочилж шинжлэх ухаан, танин мэдэхүйн "Сониучхан" цувралыг захиалаарай. Нэмэлт мэдээлэл хэсэгт patriot гэж үг бичвэл дээрх хөнгөлөлтийг олгож, тусгайлан бэлдсэн бэлгийн утгатай таван багц ном, ил захидал зэргийг гэрийн хаягаар нь хүргэж өгнө.

Тэгвэл маш сайхан бэлэг болох нь эх ...

-Ном уншдаг хүүхэд сэтгэдэг хүн болж төлөвшдөг. Хүүхэд бүр чанартай боловсрол эзэмшиж, Монголын, дэлхийн үнэ цэнтэй иргэд болж өсөж хүмүүжих ёстой. Энэ итгэл үнэмшилдээ тулгуурлаж бид шинжлэх ухаан, танин мэдэхүйн "Сониучхан" цуврал номыг нэмэлт халамж шаардлагатай хүүхдийн асрамжийн төвүүд болон 365 сумын Ерөнхий боловсролын сургуулийн номын санд хандивлаж байгаа. Энэ аяныг аав ээж, эмээ өвөөгийнхөө төрсөн нутаг Баянхонгор аймгийн Заг, Галуут сумаас эхлүүлсэн. Оны босгон дээр номоо хүлээж авсан байна лээ.

Таныг "Глобал CEO" нэвтрүүлгээр залуус сайн мэддэг

хүү чадна шүү дээ гээд дахиад л ятгав. Эхэндээ би татгалзаж байгаад надад алдаад байх юм юу байх вэ дээ гэх маягийн юм бодоод харих замдаа бүртгүүлсэн. Бүртгэлийн сүүлчийн өдөр байсан ч хэд хоногийн дараа тэнцсэн хариу авсан. Тухайн үед яг энэ "Apprentice" шиг хамгийн их үзэгчтэй болсон тус нэвтрүүлэгт орсноор өөрийгөө шинээр нээсэн гэж боддог.

Уншигчдад сонин байж магадгүй. "Глобал CEO" нэвтрүүлгийн дараа та яасан бэ?

-Сонин болгож ярихад энэ нэвтрүүлгээс өмнө хамтарч бичсэн "Интернэт хэрэглэгчийн гарын авлага" номынхоо санхүүжилтийг босгох гээд одоогийн УИХ-ын гишүүн, тухайн үед "MCS" группийн дэд ерөнхийлөгч Л.Энх-Амгалан захиралтай уулзахад намайг дөнгөж байгуулагдаж байсан "Unitel" компанийн бизнес төсөл дээр ажиллах санал тавьж Ж.Оджаргал захиралтай анх уулзуулж байсан. Мэдээж би Америкт ажилладаг байсан болохоор ийм том төслийг удирдах туршлага надад байхгүй гэж бодсон тул эелдгээр татгалзаж байлаа. Харин нэвтрүүлгийн дараа "MCS", "Моннис", "Макс" зэрэг олон компани ажлын санал тавьж байсан. Энэ дундаас "Глобал CEO" нэвтрүүлгийг зохион байгуулж, ивээн тэтгэсэн "Шунхлай" группийн П.Батсайхан захирлын саналыг хүлээж аваад "Та шинэ үеийн залууст маш сайн хөрөнгө оруулсан тул би танд өртэй. Иймд би таны удирдлагад ажилла" гэж хэлсэн. Энэ бол зарчмын асуудал байлаа. Ингээд би Монголдоо үлдэх шийдвэр гаргаж Америкт авч байсантайгаа ойролцоо түвшний цалин, урамшуулал аваад хоёр жилийн гэрээ байгуулсан. Монголдоо ажиллахын тулд магистрын хөтөлбөрөө дундаас нь хаяж, ажлаасаа гарч, АНУ-д чөлөө заваараа ажиллуулдаг байсан хувийн компаниа хаасан.

Чикагогоос тавилга, хэдэн хайрцаг номоо нүүлгэж авчрахад мөнгө шаардагдах болов уу гэж П.Батсайхан захиралд хэлэхэд надад 6000 доллар цохож өгч билээ. "Signing bonus" гэж ажилд орж байгаа хүнд нүүлгэн шилжүүлэх зардлыг өгдөг энэ барууны соёлыг хэрэгжүүлж байгаа нэг хэлбэр гэх үү дээ. Ингээд л би сүүлийн 12 жил бизнесийн салбарт ажиллаж байна. Үнэхээр сайн нэвтрүүлэг байсан шүү. Одоо ч хөдөө гадаа явах, таксинд суухад хүмүүс таниад байдаг. Хааяа уушийн газар ороход хүмүүс шар айргаар дайлах тохиолдол их гардаг. Миний үсний хэв босоо хэвээр байгаа болохоор таниад байдаг юм болов уу гэж боддог. (инээв) "MongolHD"-ийн "Apprentice" нэвтрүүлгийг үзэхийг хичээдэг. Нэвтрүүлгийн цаг Бостон, Лондон дахь түншүүдтэйгээ хийдэг цахим хуралтай яг давхцадаг

болохоор эхний гурван дугаарын сүүл хэсгийг нь л үзсэн. Их сайн нэвтрүүлэг шүү. Хийц, чанар, зураг авалт, даалгавар, шүүлт зэрэг нь маш сайн. Ч.Ганхуяг захирал сэтгэлээсээ зөвлөгөө өгч, нийгэмд үзэл бодлоо илэрхийлж байгаа нь таалагддаг. Саяхан зусланд нь зочлохдоо баяр хүргэсэн. Шүүлт шударга явагдаж байна гэж бодож байна. Нэвтрүүлэгт оролцогчдын зарим нь 10 жилийн хүүхэд, оюутан байхдаа "Глобал CEO" үздэг, намайг дэмждэг байсан гэж мессеж бичихэд нь их баярласан. Өчигдөр О.Энхжин гэж маш чадварлаг оролцогч эмэгтэй надад хандаж ийм үг жиргэхэд нь их баярласан. Энэ бүсгүйг би түрүүлэх боломжтой гэж үзэж байгаа. Түүнээс CEO хүнд байх ёстой чанарууд их тод харагддаг. Хэн ялахыг би хэлж мэдэхгүй. Хэн нь ч ялсан бай, ялагдсан бай "Ард" санхүүгийн нэгдлийн Ч.Ганхуяг захирлын хажууд маш их зүйлд суралцах тул энэ залуус өөрсдийгөө маш азтайд тооцох хэрэгтэй.

Таныг олон жил нүүр ном, жиргээнд дагаж байна. Таны карьер их хурдтай, байнга өсөлттэй яваа нь олон залууст урам зориг өгдөг. Ер нь таны ажлын гараа хаанаас эхэлсэн бэ? Яагаад Америк руу явсан юм бэ?

-Миний карьер гэж юу байх вэ дээ. Бусдын туулдаг л замнал. 5-10 дугаар анги хүртэл би аавынхаа барилгын засвар хийдэг компанид долоо хоногийн хоёр өдөр айлын ханын цаас наах, цавуу түрхэх, цонх будах ажил хийдэг байв. Ажил хийж байх зуур 20 англи үг жижиг цаасан дээр бичиж аваад өдөржин цээжилнэ. Будгийн ажил хийх үед гар хуруун дээр дуссан цагаан будаг арилдаггүй тул ангийнхнаасаа ичнэ. Заримдаа гараа ширээн доор нуудаг байж билээ.

Нэг мартагдсан дурсамж сэргэж байна. Нэг удаа Английн Элчин сайдын гэргий манай сургууль дээр ирэх болоод Алиммаа багш маань жүжиг бэлдүүлэв. Жүжгийн үзүүлбэрт ангийнхан тоглоод би англиар жүжгийн дундах тайлбар уншигч болсон юм. Элчин сайдын гэргий жүжгийн дараа надад хандаж удахгүй нэг тэтгэлэг зарлаж магадгүй, чи материалаа заавал өгөөрэй гэж хэлээд явсан. Ингээд наймдугаар ангид байхад Английн Засгийн газрын тэтгэлгээр Английн элитүүд сурдаг "Этон" коллежид хоёр хүүхэд суралцуулна гэсэн тэтгэлгийн зарыг "Ардын эрх" сонинноос уншив. Аав ээждээ ч дуулгалгүй хамаг материалаа өөрөө бүрдүүлж өгсөн. Эссэ бичив. Дүнгийн хуулбар, багш нараасаа тодорхойлолт аваад тэрийгээ өөрөө англи хэл рүү орчуулаад л. Нөгөө Элчин сайдын гэргий миний эссэг унших болов уу, яадаг бол гэхээс нойр хүрэхгүй. Ингээд 200 орчим хүүхэд өрсөлдсөнөөс сүүлийн

дөрвөн хүүхдийн нэг болж тэнцээд бөөн баяр. Гэтэл тус тэтгэлгийн шалгаруулалтыг хамтарч хийж байсан төрийн бус байгууллагын монгол ажилтан эцсийн шатны ярилцлагыг авах англи хүний нислэг хойшиллоо гэх мэт олон шалтгаан хэлж ярилцлагын тов өөрчлөхдөө нэг мэдэхэд намайг ярилцлагад оруулахгүй өнгөрөөчихсөн юм. Ээжтэйгээ Их Британийн Элчин сайдын яамны хаалга мөргөөд буцахдаа энэ хүнд гомдоод нэг их үйлж билээ. 15 настай миний бүх мөрөөдлийг хулгайлчих шиг санагдсан. Үүнээс хойш хичээлд суух хүсэл буурч аав ээжээсээ намайг Америк руу явуулаад өг гэж байнга гуйдаг болов. Өдөр бүр явах тухай бодно. Жил бүр визэнд орно. Том биетэй болох гээд аавынхаа пальтог өмсөөд очихоор Америкийн Элчин сайдын яамны консул над руу хараад, чи биеэ даагаад явахад нас чинь бага байна гээд хар тамга дарчихна. Ингээд 1998 онд дунд сургуулиа тэгсөөд 17 нас ч хүрэв. Дахиад л визэнд орлоо. Ширүүн харцтай консул над руу харж инээгээд энэ удаа виз дарж өгсөн. Аав ээж минь бүх хадгаламжаа өгсөн. Зарим мөнгийг өндөр хүүтэй зээлж аваад Америк явсан. Лос Анжелест коллежид орох үедээ би 18 нас хүрэв. 21 нас хүрээгүй тул зөөгчийн ажил олдохгүй. Ингээд Холливудын түргэн хоолны газар кассчин хийж ажлын гараагаа эхэлсэн. "Hollywood", "Sunset boulevard"-д киноны зураг авалт их болно. Жүжигчид, найруулагчид хааяа орж ирж хоол захиалахад нь их баярлана. Бүтэн жил би давхар ажил хийж, нэг ч өдөр амраагүй. Ингээд жилийн дараа гэхэд аав ээжийнхээ найз нараас зээлсэн өрийг хаагаад, хоёр улирлын сургалтын төлбөрөө өөрөө төлчихсөн, 19 насны төрсөн өдрөөрөө 1200 доллараар 1992 оны "Pontiac 6000" гэж машин авч унаад нэг их баярлаж билээ. Ажил хийгээд байгаагүй л дээ. Нэг их баян биш ч аав ээж минь намайг юугаар ч дутаагаагүй. Аав ээж минь боловсрол, ном, шударга хөдөлмөрийг дээдэлдэг сэхээтнүүд. Заримдаа ээж, аавыг яагаад хүүхдээр ажил хийлгээд байгаа юм гэж загнадаг байлаа. Харин аав хариуд нь хүүгээ би ажлын дөртэй болгож, шударга хөдөлмөрөөрөө амьдрах нь хамгийн амттай байдаг гэдгийг зааж сургаж байгаа юм гэдэг байсан. Эргээд бодоход 17 настайдаа Америкт буухад ямар ч ажлыг төвөггүй хийдэг, ачаалал даадаг болчихсон байсан. Ингэхээр миний карьер одоо обойчин

байхаас эхэлсэн гэх үү дээ. Гэхдээ миний ажил бүтэмжтэй байх бүрт би аавдаа талархаж явдаг.

Карьерын сургамж гэвэл та юу гэж хэлэх вэ?

-Би оюутан байхдаа кассчинаас эхлүүлээд туслах менежер хүртэл хоёр жил, дараа нь сургуулийнхаа лабораторид компьютерын техникчээр хоёр жил, сургуулиа төгсөөд системийн аналит, програмист буюу мэргэжилтний түвшинд гурван жил, албаны даргаар хоёр жил, гүйцэтгэх захирал, группийн дэд ерөнхийлөгчөөр нийт таван жилийн хугацаанд бүх шатанд нь ажиллажээ. Үүнийгээ аз гэж боддог. Их сургуулиа төгсөөд шууд захирал болсон хүнд мэргэжилтэн болох боломж ховор. Мэргэжилтэн байж үзсэн хүн дараа нь захирал болчихвол мэргэжилтнээсээ ядаж л юу шаардахаа мэднэ. Иймд цагийн юмыг цагт нь сураад явахад гэмгүй. Нэг ёсондоо лифтэнд суухгүйгээр шат шатаар ахиад явчихвал шат буурсан ч гэнэт нэг их доошоо унаад байхгүй юм болов уу даа. Одоо би өөрийн хувийн бизнесүүдийг удирддаг. Хоёрт Жак Магийн хэлдгээр 30 нас хүртэл сайн лидерийн удирдлагад ажиллаад юм сураад авбал сайн гэж захидаг. Энэ их үнэн. Миний хувьд эргээд бодоход "Шунхлай" группийн ерөнхийлөгч П.Батсайхан, "Моннис" группийн ерөнхийлөгч Б.Чулуунбаатар гээд Монголын шилдэг бизнесийн лидерүүдийн гар дор ажиллаж, маш их зүйл сурсан. Надад хийж бүтээх эрх чөлөө олгож, байнга дэмжиж байсанд нь одоо ч талархдаг.

Таны алхам тутамдаа баримталдаг зарчим юу вэ?

-Хэлсэндээ хүрэх. Тухайн үед амжихгүй, чадахгүй тохиолдол гарахыг үгүйсгэхгүй ч хэзээ нэгэн цагт биелүүлж, дуусгаж байж санаа амардаг. Бас аливаа зүйлийг ядаж л өөрийн санаанд хүртэл хийж гүйцэтгэхийг хичээдэг. Энэ нь нэг талаар цагийн дайсан байдаг ч нөгөө талаар ирээдүйдээ маш их цаг хэмнэх үндэс болдог. Нэг ёсондоо цаглашгүй зүйлийн төлөө тэмүүлэх нь маш чухал. Нөгөө нь шударга байх, үнэт зүйлдээ үнэнч, цуцашгүй хөдөлмөрч байх явдал. Энэ гурван зүйлийг баримталж чадвал хэзээ нэгэн цагт үр дүнг нь үзнэ.

Эх орны үнэ цэн юунд оршдог гэж боддог вэ?

-Их сургуулиудад хааяа яриа хийхдээ хэлдэг хэд хэдэн санаагаа давтаж хэлбэ. Яагаад та бид, манай залуу үе, бидний дараа үе эх орноо хөгжүүлэх ёстой вэ, яагаад та бүхэн эх орноо батлан хамгаалж, хилээ манадаг вэ, ер нь бүгдээрээ Аргентин яваад тэнд усан үзэм тариад амьдардаггүй нь ямар учиртай вэ? Чингис хаанаас Лигдэн хаан хүртэл, залгаад Амарсанаа, Чингүнжав, Богд хаан, Бодоо, Данзан, Чойбалсан, Цэдэнбал гээд 90 оны ардчилсан хувьсгалыг хийж, эдийн засаг улс төрийн хувьд бүрэн тусгаар тогтноулахад хувь нэмэр оруулсан хүн бүр эх орныхоо төлөө төрсөн гавьяатай хүмүүс. Өмнөх бүх үе Монголын тусгаар тогтнолыг авч үлдэж, бидэнд өвлүүлсэн. Энэ тэмцэл нь маш олон жил үргэлжилсэн, даанч их зовлон, гуниг, дарангуйлал дамжсан маш хүнд түүх байдгийг бид мартаж учиргүй. Бидний эх орон бол та, би, та бидний эцэг эх, таны хөрш, гудамжинд яваа хүн, дээр дурдсан хүмүүс, тэдний үнлэмж, итгэл, мөрөөдөл, бүх зүйл нийлээд юм. Иймд та өөрийгөө хөгжүүлнэ гэдэг нь эх орноо хөгжүүлж буй хэрэг. Мэдээж та космополитан хүн байж болно. Гэлээ гэхдээ та яаж ч мэтгээд монгол хүн хэвээрээ. Монгол гэдэг нэр бол та бидний үүрдийн овог. Чиний угшлын нэр. Чиний сонгодог, туйлын оршихуйн нэр. Монгол бол чи бидний оршихуй юм. Чи бидний оршихуйн үг үндэс, суурь шалтгаан нь юм. Монголыг үгүйсгэнэ гэдэг бол чи өөрийгөө болоод өөрийнхөө гэр бүлийн модыг тань ургуулсан үндэс, угсаа, мөчир болгоныг үгүйсгэж буй хэрэг. Нэг ёсондоо чи өөрийгөө үгүйсгэж буйн хэлбэр. Хэрэв хэн нэгэн чамайг биш ч монгол эх орон, ард нийтийг маань дорд үзвэл тэр бол өөрөө маш том гутамшиг, доромжлол юм. Гэхдээ чамайг муулсан бол чи тайван байж болно. Харин тэгж доромжуулахгүйн тулд бид өөрсдөө сайн байж ёстой. Эцсийн дүндээ хүн болоод амьд байгаль оршихуйн төлөө байдаг. Тэр оршихуй тань Монгол бөгөөд Монголын сэргэн мандал юм.

Цаг гарган ярилцсанд баярлалаа. Танд амжилт хүсье.

Ахмад Д.МЭНДБАЯР



ОХУ-ЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН 2021 ОНД

ШИНЭЭР АВАХ ЗЭВСГҮҮДЭЭ ТАНИЛЦУУЛАВ

ОХУ-ын Зэвсэгт хүчин 2021 онд шинэ зэвсэг, техник үргэлжлүүлэн хүлээн авахаар төлөвлөж байна. Энэ талаар Оросын хэвлэлүүд ийн онцолжээ.

Энэ тухай дурдахаас өмнө сүүлийн зургаан жилийн хугацаанд ОХУ-ын Зэвсэгт хүчин 57 нэгж цэргийн зориулалт бүхий сансрын хиймэл дагуул, 109 нэгж "Ярс" тив хоорондын баллистик пуужин, 108 нэгж шумбагч онгоцны баллистик пуужин, гурван нэгж "Борей" ангиллын шумбагч онгоцны пуужингийн крейсер, долоон нэгж орчин үеийн шумбагч онгоц, 161 нэгж десантын хөлөг онгоц, 17 нэгж эргийн хамгаалалтын пуужингийн цогцолбор, мянга гаруй нэгж байлдааны нисэх онгоц, нисдэг тэрэг, 3,5 мянга гаруй, хуягт тээвэрлэгчийг зэвсэглэлд авчээ. Мөн пуужингийн 12 анги нэгтгэл "Ярс" цогцолбор, пуужингийн 10 бригад "Искандер-М" цогцолбор, зенит пуужингийн 20 анги, нэгтгэл "С-400" зенитийн пуужингийн цогцолбороор тус тус зэвсэглэгдээд байна. Үүний зэрэгцээ Агаар-сансрын цэргийн 13 хороо шинэ үеийн дөрвөн төрлийн нисэх онгоц /МиГ-31БМ, Су-35С, Су-30СМ, Су-34-ийг, гурван бригад байлдааны нисдэг тэрэг "Ка-52", "Ми-28"-ийг зэвсэглэлд авчээ.

ТИВ ХООРОНДЫН БАЛЛИСТИК ПУУЖИН РС-28 "САРМАТ"

2021 онд Стратегийн пуужинт цэргийн хүчин РС-28 "Сармат" тив хоорондын шинэ баллистик пуужинг зэвсэглэлд

хөдөлгүүртэй бөгөөд пуужингийн нэгдүгээр үе нь РД-274 гэдэг нэртэй дөрвөн хөдөлгүүрээр тоноглогдоно. Зэвсэгт хүчний төлөвлөгөөнд тусгаснаар удахгүй Северо-Енисейгийн туршилтын полигонд "Сармат" пуужингийн цогцолборын хөөрөг туршилтыг хийх ажээ.

ДУУНААС ХЭТ ХУРДАН ПУУЖИН "ЦИРКОН"

"Циркон" /ЗМ22/ дуунаас хэт хурдан, хөлөг онгоц эсэргүүцэгч далавчит пуужин нь ЗК22 "Циркон" цогцолборын



нэгэн хэсэг юм. Энэ нь ЗХУ-ын үеийн хүнд даацын П-700 "Гранит" хөлөг онгоц эсэргүүцэгч пуужинг орлоно. Уг пуужингийн бусад пуужингаас ялгагдах үндсэн ялгаа нь Оросын бусад хөлөг онгоц эсэргүүцэгч пуужин болон бусад оронд ашиглагдаж буй хөлөг онгоц эсэргүүцэгч пуужингаас нислэгийн хурдаараа эрс ялгаатай бөгөөд "Мач 8" буюу дуунаас 8 дахин хурдтай юм.

"Циркон" пуужингийн гол

ын ОЕС-Кузнецов корпораци нь "НК-32" цуврал хоёр хөдөлгүүр үйлдвэрлэх гэрээг байгуулж, 25 жилийн турш түр зогссон ажлыг дахин эхлүүлсэн байдаг.

пуужинт байг илрүүлэх, нэгэн зэрэг цохилт өгөх, түүнчлэн дуунаас хурдан далавчит пуужингийн цэнэгт хошууг устгах хүчин чадалтай.

Тус улсын зэвсгийн шинжээчид С-500 "Прометей" систем нь агаарын довтолгооноос хамгаалах систем бус харин сансрын довтолгооноос хамгаалах систем гэж нэрлэгдэх болно хэмээн үзэж байгаа. Учир нь С-500 "Прометей" систем нь нам дор тойрог замд хиймэл дагуул болон дуунаас хэт хурдан зэвсгийг устгах хүчин чадалтай бүтээгдсэн байна. ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин "... дуунаас хэт хурдан зэвсгийг дэлхий дээр зөвхөн ОХУ үйлдвэрлэсэн бөгөөд үүгээрээ орчин үеийн дэвшилтэт зэвсэглэлээрээ дэлхийд тэргүүлж

нь Зэвс бурхны мэдэлд байсан галыг авч хүмүүст өгснөөр хүн төрөлхтнийг устгах гэсэн аянгыг захирагч Зөвсийн хорон санаат төлөвлөгөөг нураадаг. Энэ утгаараа ОХУ сансрын довтолгооноос хамгаалах нэгдүгээр үеийн зэвсгээ ийнхүү нэрлэжээ.

ТАВДУГААР ҮЕИЙН СӨНӨӨГЧ ОНГОЦ "СУ-57"

Тавдугаар үеийн сөнөөгч онгоц Су-57 нь агаар, хуурай газар, газрын гадаргуу дээрх бүх төрлийн байг устгахад зориулагдсан агаарт давамгайлах олон зориулалтат сөнөөгч онгоц юм. Дуунаас хурдтай, бүрэн зэвсэглэсэн, радио шингээгч бүрхүүлтэй буюу радарт үл илрэх технологиор бүтээгдсэн, мөн онгоцны их биедээ хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсоноороо онцлог. 2021 онд ОХУ-ын Агаар-сансрын



байна" гэж 6 дугаар сард "Россия-1" телевизийн сувгаар мэдэгдэж байсан. Тактикийн болон техникийн шинж чанараас нь үзэхэд С-500 "Прометей" систем нь нам дор тойрог замд хиймэл дагуул, сансрын зэвсгийг устгах боломжтой тул "Нэгдүгээр үеийн сансрын довтолгооноос хамгаалах систем" гэж үзэж болно хэмээн ОХУ-ын Агаар-сансрын хүчний ерөнхий командлагч Сергей Суровикин мэдэгдэж байсан. С-500 "Прометей" сансрын довтолгооноос хамгаалах систем нь аэродинамик, баллистик байг устгах, түүнчлэн дуунаас хэт хурдан зэвсэг, тив алгасагч баллистик пуужин, ойрын зайд байрлах хиймэл дагуул зэргийг устгах чадалтай юм.

"С-500 "Прометей" системийн байг устгах алслалт нь 600 гаруй км бөгөөд энэ нь

хүчин дөрвөн нэгж "Су-57" сөнөөгч онгоц зэвсэглэлд хүлээн авна. Цаашид жил тутамд 15 нэгж "Су-57" сөнөөгч онгоц зэвсэглэлд авахаар төлөвлөсөн байна.

T-14 "АРМАТА" ТАНК

Ойрын ирээдүйд хуурай замын тулалдаанд Т-14 "Армата" танк ноёлно гэж зэвсгийн шинжээчид үзэх нь буй. Маш сайн сайжруулсан хуяг нь хүчтэй дэлбэрэлтийг ч тэсвэрлэдэг бөгөөд 125 мм-ийн их буугаар байг бүрэн устгах чадалтай. "Армата" нь ганцхан төрлийн байлдааны хуягт машин биш бөгөөд олон зориулалтын хуягт платформ юм. Өөрөөр хэлбэл, нэг маягийн явах эд ангийн суурин дээр үндэслэн байлдааны танк, явган цэргийн байлдааны машин, танк дэмжих байлдааны машин, хуягласан инженерийн болон татан гаргалтын машин,



авна. Шингэн түлштэй эдгээр аварга пуужингууд нь Стратегийн пуужинт цэргийн хүчинд ашиглагдаж байгаа ЗХУ-ын үед үйлдвэрлэгдсэн Р-36М2 "Воевода" пуужингуудыг орлох ажээ. Тив алгасан нисэх баллистик пуужин РС-28 "Сармат"-ыг 2011 оноос эхлэн хөгжүүлж эхэлсэн бөгөөд пуужин нь дайсны пуужингийн довтолгооноос хамгаалах системийг даван туулж Хойд туйл болон Өмнөд туйлаар дамжин цель рүү довтлох тактик техникийн үзүүлэлттэй ажээ. Зэвсгийн мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар пуужин нь байлдааны хязгааргүй алслалттай тул ямар ч чиглэлд цель цохилт өгөх хүчин чадалтай юм. Түүнчлэн, "Сармат" нь богино өргөгч хэсэгтэй тул тив хоорондын баллистик пуужингийн хөөрөх идэвхтэй үе шатыг хурдасгаснаар дайсан пуужингийн довтолгооноос хамгаалах системийг ашиглан амдан устгахад төвөгтэй болжээ. "Сармат" нь дуунаас хурдан зэвсэг тэргүүтэй өргөн алслалт бүхий цөмийн олон төрлийн зэвсэг, хамгийн орчин үеийн пуужингийн довтолгооноос хамгаалах системээр тоноглогдох боломжтой. "Сармат" пуужингийн дайсны байг онож устгах байлдааны алслалт нь 18000 км, пуужингийн хөөрөх жин нь 208,1 тонн буюу ачааны жин нь 10 тонн, түлшний жин нь 178 тонн ажээ. Пуужингийн урт нь 35,5 метр, диаметр нь 3 метр бөгөөд цэнэгт хошууны төрөл нь тус тусдаа удирдан чиглүүлэх нэгж бүхий олон цэнэгт хошуунаас бүрдэнэ.

Одоогийн байдлаар Сармат пуужингийн цогцолборын улсын нислэгийн туршилтуудын бэлтгэл ажил хийгдэж байна. НАТО уг пуужинг "Шулам" гэж нэрлэсэн. Шингэн түлшний

зорилго нь фрегат /байлдааны дунд оврын усан онгоц/-аас нисэх онгоц тээгч хүртэлх олон төрлийн ангиллын хөлөг онгоцнууд, түүнчлэн газрын байршилд цохилт өгөх хүчин чадалтай. "Циркон"-ы хурд 9800-11025 км/цаг буюу 2700-3062 м/сек юм. Өөрөөр хэлбэл, дэлхийн улсуудад ашиглагдаж буй пуужингийн довтолгооноос хамгаалах цогцолборууд уг пуужинг амдан устгах боломжгүй гэсэн үг. Түүнчлэн дайсан уг пуужин хөөрснийг илрүүлэх болон пуужингаас зайлсхийх боломжгүй гэж онцолжээ.

СТРАТЕГИЙН БӨМБӨГДӨГЧ ОНГОЦ "ТУ-160М/М2"

"Ту-160М/М2" бол олон горимт, дуунаас хурдан стратегийн бөмбөгдөгч онгоц юм. Тус онгоц нь бүрэн шинэчлэгдсэн нисэхийн электрон төхөөрөмж, хөдөлгүүрээр тоноглогдсон байх ажээ. Ирэх оны дөрөвдүгээр улиралд онгоцны анхны туршилтын нислэг хийгдэнэ. "Ту-160М2"-ийн гол үзүүлэлт нь яахын аргагүй түүний шинэчлэгдсэн хөдөлгүүр юм. 2014 оны 8 дугаар сард ОХУ-

Оросууд "НК-32-02" хөдөлгүүрийг 1987 онд бүтээсэн боловч санхүүжилтийн асуудлаас болж үйлдвэрлэх үйл явц зогссон байна. ОЕС-Кузнецов корпорацийн шинэчлэлийн хүрээнд хөдөлгүүрийн компрессор, турбины ир, дотоод аэродинамик, хөргөлт зэрэгт өөрчлөлт оруулж байгаа ажээ. Үүний үр дүнд түлшний зарцуулалт буурах ч 25 тонн хөөрөх хүч нь өөрчлөгдөхгүй хэвээр үлдэх аж. Туполевийн Зохион бүтээх товчооны гүйцэтгэх захирлын мэдээлснээр "Шинэ хөдөлгүүрүүд болон үндсэн ачаа нь 9 тонн жинтэй 6 далавчит пуужингийн хамт "Ту-160" бөмбөгдөгч онгоцыг 13950 км замыг туулуулж чадна гэж заасан бөгөөд энэ нь стандарт хувилбараас 1650 км-ээр илүү үзүүлэлт юм" гэдгийг цохон тэмдэглэжээ.

Түүнчлэн онгоцны навигац, холбоо, хамгаалалтын системүүд бүрэн шинэчлэгдэж хамгийн орчин үеийн технологи шингээсэн шинэ төхөөрөмжүүдээс бүрдэх ажээ. 2021 онд ОХУ-ын Батлан хамгаалах яам шинэчлэгдсэн "Ту-160М/М2" бөмбөгдөгч онгоцны туршилтын нислэгийг эхлүүлэхээр төлөвлөж байна. Харин 2023 оноос Оросын Зэвсэгт хүчний Агаар-сансрын цэргийн хүчин эхний ээлжийн "Ту-160М/М2" бөмбөгдөгч онгоцыг зэвсэглэлд хүлээн авах бөгөөд 2027 он гэхэд ОХУ 10 нэгж "Ту-160М/М2" бөмбөгдөгч онгоцыг зэвсэглэлд авсан байхаар төлөвлөж байна.

ЗЕНИТИЙН ПУУЖИНГИЙН ЦОГЦОЛБОР С-500 "ПРОМЕТЕЙ"

Зенитийн пуужингийн цогцолбор С-500 "Прометей"-г 2021 онд зохион бүтээж дуусгахаар төлөвлөсөн. Энэ нь дэлхийн агаар мандлын гадна байрлах маш өндөрт харвасан баллистик пуужинг амдан сөнөөж устгах зориулалттай алсын зайн тусгалт өвөрмөц цогцолбор юм. С-500 цогцолборын байлдааны алслалт 600 км бөгөөд 7 км/секунд хурдтай нисэж байгаа 10 хүртэлх тооны баллистик



алсын тусгалтайд тооцогдоно. Нөгөөтэйгүүр С-400 зенит пуужингийн цогцолбор дунджаар 9-10 секундэд хариу цохилт өгдөг бол С-500 систем нь ердөө 3-4 секундэд цохилт өгөх чадалтай гэдгээрээ давуу талтай юм.

Пуужингийн нислэгийн траекторийн сүүлчийн хэсэг дэх чиглүүлэлтийг инерцийн удирдлага, радиолокацийн хагас идэвхт өөрөө чиглүүлэлт болон давхар диагоны дулааны дүрс харагдалтын технологийг нэгэн зэрэг ашиглан гүйцэтгэдэг байна. Сүүлд дурдагдсан технологийг ашигласнаар жинхэнэ пуужинг хуурамчаас ялгах, радарт учрах саадыг тусгаарлах боломжтой болжээ.

ОХУ С-500 цогцолбороо эртний Грекийн үлгэр домгийн баатрын нэрээр "Прометей" гэж нэрлэсэн байна. Прометей

өөрөө явагч артиллерийн систем зэргийг үйлдвэрлэх боломж олгосноороо онцлог ажээ.

T-14 "Армата" нь 125 мм-ийн "2А82-1М" их буутай, тоон системээр алсын зайнаас бүрэн удирдагдах, танкийн экипажид цамаг байрладаггүй байлдааны үндсэн танк юм. Мөн 1800 морины чадалтай, турба үлээлттэй, 12 цилиндртэй дөрвөн тактын Х хэлбэртэй дизель хөдөлгүүрээр тоноглогдсон байна. Түүнээс гадна төрөл бүрийн зориулалттай 32 их бууны сумаар тоноглогдсон. Мөн "Армата" дэлхийн хамгийн анх үл үзэгдэгч технологиор бүтээгдсэн танк бөгөөд хэт улаан туяа, радио соронзон оронд үзэгдэх байдал нь эрс багассанаар бараг л "сүнс" гэж хэлж болно.

Ахмад М.МӨНХЗОРИГ

БОГД ХААНЫ ЗАРЛИГ

Цэргийн яамнаас харьяат яамны орон гаргасан тэргүүн сайдыг тохоон талбиулах явдлыг айлтгуулан мэдэгдэн ирсэн хэрэг.

Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны бичиг.

Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаа өргөн илгээв.

Явуулах учир, Цэргийн засгийг явуулах газрын өргөсөн нь, Энэ өвлийн сүүл сарын шинийн нэгнээ манай яамнаас айлтгасан нь, орон гарсан тэргүүн сайдыг тохоон талбиулах явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад Богд эзэн гэгээнээр томилж заан

сурахыг гуйх учир. Мөнөөхөн манай яамны тэргүүн сайд, Эрдэнэ далай ван Го өвчнөөр нэгэнт бие өнгөрсөн явдлыг үүний урьд айлтгаад буулгасан зарлигийг хичээнгүйлэн дагаж шийтгэсэнээс гадна, шавь боолчууд хянаваас, манай Цэргийн яам болбоос улсын чухал цэргийн засгийг явуулах



их яам бөгөөд тэргүүн сайдын тушаалыг удтал хийдүүлбээс үл болохын тулд харьяат яамны орон гарсан тэргүүн сайдыг тохоон талбиулах явдлын зүй нь зарлигийг гуйн айлтгаж заан сургахыг хүлээбээс зохихын тул хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад Богд эзэн гэгээнээр томилогч заан сургах ажаамуй, Үүний тул хичээнгүйлэн айлдав, зарлигийг гуймой, хэмээн айлтгасанд мөнхүү өдөр хүлээн авсан уг нугалбар улаан бийрээр цохсон, зарлиг Дотоод яамны дэд сайд Доржпаламыг Цэргийн яамны тэргүүн сайдад тохоон талбигтун хэмээснийг хичээнгүйлэн дагаж үүний шинэ тушаалын тэргүүн сайд, Дотоод яамны дэд сайд, Үнэн сүжигт, элдэн жүн ван Дад явуулаад уг айлтгасан хэрэг байгуулсан зарлигийг хичээнгүйлэн дагаж даруй


Дээрийн хишигт мөргөж, тамга хэргийг хүлээн авч хэрэг шийтгүүлмой, үүнийг басхүү Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаа явуулаад байцаан үзэж, тэргүүн сайд, Үнэн сүжигт, элдэн жүн вангийн биеийг авч

Дээрийн хишигт мөргүүлэх ажаамуй, үүний нэгэнтэйгүүр Бүгд ерөнхийлөн захирах яамны зэрэг явуулаад тушааваас зохих олон газар нэгэн адил явуулаад тушаан байцаан үзүүлмой, хэмээн өргөжээ.

Үүний тул өргөн илгээв.

Олноо өргөгдсөний дөрөвдүгээр он арван хоёр сарын шинийн хоёр МУУТА, ТБА, ХА-3 Д-1, ХН-530, Б-40.

БАТЛАН ХАМГААЛАХЫН ТӨВ АРХИВ



Б.Намуун: ТАЕКВОНДО БОЛ ХҮНДЛЭЛИЙН СПОРТ

Өнгөрсөн зун нүүр ном нэг хэсэгтээ л энэ зургаар давалгаалж, залуус ч үүнийг дор нь гогодож аваад чэлленж хүртэл эхлүүлснийг та бид мэднэ. Тэгвэл дээрх зургийн эзэн нь Монгол Улсын таеквондогийн шигшээ баг, "Алдар" спорт хорооны тамирчин, олон улсын хэмжээний мастер Б.НАМУУН юм.

Цар тахлын дэгдэлттэй амаргүй цаг үе байна. Энэ цаг үеийг хүмүүс нэг талаас өөрийгөө хөгжүүлэх боломж гэж харж байх шиг. Таны хувьд эдгээр өдрүүдийг хэрхэн өнгөрүүлж байна вэ?

-Мэдээж улсын онцгой комиссын шийдвэрийг дагаж тамирчин бид дор бүрнээ иргэний үүргээ ухамсарлан хөл хөдөлгөөнөө багасгаж, гэрийн нөхцөлд бэлтгэл сургуулилтаа хийж байна. Хичээл сургууль ч цахим хэлбэрт шилжсэн болохоор хувь хүний хөгжил, боловсролдоо түлхүү анхаарч байна.

Хамгийн анхны тэмцээн ямар дурсамж үлдээснийг сонирхоё ...

-2014 оны 1 дүгээр сард болсон "Хөтөлийн цом" тэмцээн байсан. Тухайн үед таеквондоогоор хичээллээд дөнгөж гурван сар гаруй хугацаа өнгөрөөд байв. Анхны тэмцээн байсан учир битүүхэн догдолж, бас тийм дайны сандрал наймаг бага зэрэг түгшээсэн. Хамгийн тод санаж байгаа зүйл гэвэл яг тулалдахын өмнөхөн нөгөө сандрал, сэтгэл түгшил хаалгаар гараад явчихсан. Хаашаа ч юм бэ дээ алга болчихсон.

Тэрхэн эгшинд юм юм л болоод өнгөрч дээ ...

-Дараа нь эрэмгий, зоригтой болчихсон ч юм шиг санагдаад л. Чих нь улайгаад, нүд нь улаанаараа эргэлдээд гэж ээж, багшдаа шоолуулж байсан даа /Инээв/. Тэгээд анхны тэмцээнээсээ мөнгөн медаль хүртсэн. Аваргын төлөөх тулаанд маш ойрхон өрсөлдөөнийг үзүүлсэн гэж боддог. Ердөө гурван онооны зөрүүтэй хожигдсон болохоор тухайн үед дэвжээгээсээ бууж ирээд асгартлаа үйлж байсан минь санаанаас гардаггүй. Тэр үед л өөрийгөө ямар шартай хүн бэ гэдгээ мэдэж авсан.

Авыгаадагаж спортод хөл тавьсан бол эзгийнхээ зөвлөгөөгөөр таеквондогийн спортоор хичээллэх болсон гэсэн. Эмэгтэй хүнд бага зэрэг хатуудсан спорт юм шиг санагддаг. Таны хувьд ...

-Хатуу ч гэсэн сонгодог, тансаг спорт. Анх 2013 онд "Олимп" таеквондогийн клубд очиход надад мэдрэгдсэн тэр мэдрэмж одоо ч тодхон. Зааланд бэлтгэл хийж байгаа ах эгч нар, үе тэнгийнхэн гээд бүгд цав цагаан өмсгөлөөр жигдэрсэн нь нүдэнд их өртөж, бас нэгэн зэрэг чангаар тоолоод, дасгал сургуулилтаа хийж байсан нь цаанаа л сурдмээр. Тэр дүр зураг наймаг таеквондогийн спортод гүн дурлуулсан гэж болно. Мэдээж өнөөдрийг хүртэл хүнд ачаалал, бэртэл гэмтэл авч, уналт босолт, ялалт ялагдал гээд бүхий л зүйлийг мэдэрсэн. Гэхдээ биеэ хамгаалах чадвар, тууштай байдал, тэсвэр тэвчээр, аливаа зүйлийн аргыг нь олох гүйлгээ ухаан, бусдадаа үлгэрлэх, хамт олноо удирдан чиглүүлэх овжин зан гээд амьдралд хэрэгтэй олон чанарт суралцсан гэж боддог. Тиймдээ ч амжилтыг зөвхөн дэвжээн дээрээс олддогийг гэдгийг ойлгосон. Таны хэлсэнчлэн эмэгтэй хүнд чанга, хатуу мэт

санагдах боловч ирээдүйд үүнээс ч илүү хэцүү байхыг үгүйсгэхгүй. Тэр үед л өөртөө итгэх итгэлээ алдахгүй байвал тэмцэх чадвараа ч бас хадгалж чадна. Ер нь ямар ч цаг үед. Хатуу ч гэсэн энэ спортод маш их хайртай.

Шантарч байсан үе байдаг л биз дээ. Юунаас хамгийн их эрч хүч авдаг вэ?

-Тийм үе зөндөө. Гэхдээ тэр болгонд би ганцаараа шантраагүй гэдгээ мэддэг. Багийн хамт олон маань ч ялгаагүй ядардаг болохоор ганцхан надад хэцүү байна гэх нь утгагүй хэрэг. Харин хүнд, хэцүү үед бие биеэ хурцалж, зоригжуулах ямар их эрч хүч өгч, дэм болдгийг маш сайн ойлгосон. Баг, хамт олноосоо маш их эрч хүч авдаг.

Таеквондогийн спортын онцлог, давуу талыг юу гэж хардаг вэ?

-Бусад гардан тулаантай спортыг бодвол харьцангуй шударга санагддаг. Учир нь бидний тулалдахдаа өмсөж буй хамгаалалтын хувцас, хэрэглэлүүд бүгд цахимжсан байдаг болохоор шүүлтийн хувьд ямар нэгэн будлиан үүсдэггүй. Зарим спортын хувьд тулааны рингэн дээр илт илүүрхэж байсан тамирчин төгсгөлд нь хүссэн үр дүндээ хүрч чадахгүй байх тохиолдол бишгүй л бий. Таеквондогийн хувьд тийм зүйл ховор болохоор шүүлтийн хувьд шударга гэж бодож байна.

Гаргаж байсан амжилтуудаасаа дурдахгүй юу?

-Ази, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс бага насны ангилалд хүрэл медаль хүртэж байсан. Мөн Оюутны дэлхийн аваргын хүрэл медальтай, Монгол Улсын найман удаагийн аварга.

Мэдээж амжилт бүрийн цаана хөлс хүч, хөдөлмөр бий. Хамгийн их хөлс хүч асаруулсан, хамгийн хүнд нь ямар тэмцээн байсан бэ?

-2018 оны Дэлхийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн юм болов уу. Дөрвөн удаагийн маш хүнд тулааныг хийсэн. Ингэхдээ хүрэл медалийн болзол хангах шийдвэрлэх тулаандаа ялагдал хүлээж, тус тэмцээнийг харамсалтайгаар өндөрлүүлсэн юм.

Машины багажийг хөлөөрөө хааж байгаа таны зураг цахим орчинд тавигдсанаар бүр чэлленж болтлоо давалгаалсан. Бас зургийн эзэн хэн бэ гэсэн асуулт залуусын дунд их хөвөрсөн. Ингэлтээ олон хүнд хүрнэ гэж бодсон уу?

-Тухайн үед хүмүүст тодорхой хэмжээнд хүрнэ гэсэн төсөөлөл байсан. Учир нь тиймэрхүү зураг Монголд харгагдаж байгаагүй болохоор. Бараг хоёр жил гаруй хугацаанд бодож байгаад өнгөрсөн зун авахуулсан юм. Санасныг бодвол маш олон



зүйлдээ залбирч, бясалгах нь наймаг илүү тайван болгож, өөртөө итгэх итгэлийг минь нэмэгдүүлдэг.

Өөрийгөө хамгийн их хурцалж байсан үе ...

-Хүн өөртэйгөө харилцаж, ойлголцох нь амжилтын гол хүчин зүйл. Өдөр бүр л өөрийгөө хурцалж, өөртэйгөө ярилцдаг.

Спорт болон амьдралдаа баримталдаг алтан дүрмээсээ хуваалцахгүй юу?

-Таеквондо нь хүндлэлийн спорт учир ямагт багш дасгалжуулагч, ах эгч, найз нөхдөө хүндэлж, бидний ирээдүй болсон дүү нартаа үлгэр дуурайл болох нь бидний үүрэг бас хариуцлага. Энэ утгаараа бусдыг хүндлэх, бусадтай алив сайхан гэсэнээ хуваалцдаг. Энэ нь үзэл баримтлал гэхээс илүүтэй дадал зуршил болчихсон гэхэд буруудахгүй.

Дэлгэцийн хэд хэдэн бүтээлд тоглож өөрийн гэсэн орон зайг бий болгож чадсан. Кино, дэлгэцийн урлагт хэр сонирхолтой вэ?

-Мэдээж залуу байхдаа өөрийгөө аль болох олон зүйлд сорьж, авьяас чадвараа нээх нь зөв гэж боддог. Тийм ч учраас завтай боломжтой үедээ дэлгэцийн уран бүтээл, загварын ертөнцөд өөрийгөө сорихыг эрмэлздэг. Гэхдээ түүнээс илүүтэй нэн тэргүүнд тавьсан зорилгодоо хүрэх нь чухал болохоор бусдыг нь сонирхол хоббигоо болгодог.

Б.Намуунагийн спортоос гадуурх амьдралын талаар сонирхмоор санагдлаа. Чөлөөт цагаараа юу хийх дуртай вэ, спортоос өөр сонирхдог зүйл бий юу?

-Чөлөөт цагаараа аль болох гэртээ байхыг илүүд үздэг. Учир нь бид тэр бүр гэр бүлтэйгээ хамт байж, олон цагийг өнгөрөөж чаддаггүй шүү дээ. Боломж гарвал гэртээ шигдчихдэг зантай. Мөн кино үзэх, ном унших дуртай. Учир нь заримдаа бид амьдралаас авч чадахааргүй уран тансаг мэдрэмжийг кино, дуу, номоос олж харах боломж бүрддэг юм шиг санагддаг.

Өөрийгөө хамгийн энгийнээр тодорхойлолбол ...

-Аав, ээжийн хайртай охин, ах эгчийн хайртай дүү.

"Алдар" спорт хорооны тамирчин болж байсан тэр үе рүү буцъя ...

-Ах нар маань надаас өмнө "Алдар" спорт хорооны тамирчин болж байсан. Харин миний хувьд 2016 онд болсон. Монголын бүх ард түмний спартакиадад "Алдар" спорт хорооны нэрийн өмнөөс ах нартайгаа хамт нэг баг болоод амжилттай оролцож байлаа. Түүнээс хойш тав дахь жилдээ "Алдар"-аараа овоглоод олон тэмцээн уралдаанд оролцож байна.

Үнэхээр л "Алдар"-ын Намуунаа гэхээр их дотно сонсогддог шүү ...

-Олон жилийн түүхэн замналтай "Алдар" спорт хорооны тамирчдын эгнээнд багтаж явдагараа би бахархдаг. Бидэнд бэлтгэл сургуулилт хийх, тэмцээн уралдаанд оролцоход гүн туслалцаа үзүүлж байдаг "Алдар"-ынхаа удирдлагуудад чин сэтгэлийн талархал илэрхийлмээр байна. Цаашид спорт хорооныхоо алдар хүндийг өндөрт өргөж явна гэдгээ илэрхийлье.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
САНЖМЯТАВЫН
ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо" сонин
редакцад бэлтгэж,
"Соёмбо принтинг" хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламныг хямд нийтэлнэ.
*Зар, рекламны үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029